| 8                       | Хог хаягдлаар хөрсөн бүрхэвч бохирдох | Хог хаягдлыг ил задгай хаях, хөрс бохирдуулахаас сэргийлж хог хаягдлын менежментийн журмыг мөрдөж ажиллах.                                      | Үйл ажиллагааны турш | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав. | Уурхайн талбайн хэмжээнд энгийн болон аюултай хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд дээр ангилан ялгалттай хогийн сав байршуулж, хогийн цэг дээр түр хадгалан эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлэн үстгүүлсэн. (Дэлгэрэнгүйг 3.1.8-с үзнэ үү)   |
| <b>Нийт зардал, төг</b> |                                       |   |                      |  | <b>7,050,000</b>   |

### 3.1.1 Газар хөндөлт


Газар хөндөх, шимт хөрс хуулах, хадгалахтай холбоотой дотоод журмыг боловсруулж нийт ажилчдад танилцуулан мөрдүүлэн ажиллаж байна.

### 3.1.2 Шимт хөрсний хуулалт

Газар хөндөх, шимт хөрс хуулах, хадгалахтай холбоотой дотоод журмыг боловсруулж нийт ажилчдад танилцуулан мөрдүүлэн ажиллаж байна.

2025 онд төслийн талбайн хэмжээнд уурхайн олборлолтын ажил 2-р улирлаас эхэлсэн бөгөөд уурхайн баяжуулах үйлдвэр, ажилчдын кемп, ШТС-ын барилгын ажил явагдаж байна.

“Эрдэнэс Цагаан Суварга” ХХК нь газар ашиглалтыг үр бүтээлтэй байлгахын тулд барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх газрын эвдрэлийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах, хянах, бүртгэх зорилгоор газар хөндөх зөвшөөрлийн хуудас болон шимт хөрсний бүртгэлийн хуудсын дагуу хүсэлтүүдийг хүлээн авч, шийдвэрлэдэг.



The image shows two forms side-by-side. The left form is titled 'Газар хөндөх үүрэгтэй Эрдэнэс Цагаан Суварга Газар хөндөх зөвшөөрлийн хуудас' and contains sections for project details, types of land disturbance (e.g., excavation, foundation), and management measures. The right form is titled 'ХӨНДӨГДЭЭР ХЭСЭГ, ХҮСЭЛТ ГАРГАГЧ БОГЛОМЬ ТЭХМӨЛӨГӨЙН ИНАХ НЕ Р БАГЦААН' and contains sections for soil management measures, including erosion control and soil conservation, with checkboxes for various methods like mulching and terracing.

Зураг 3-1. Газар хөндөх зөвшөөрлийн хуудас

2025 оны тайлант хугацаанд нийт 4 газар хөндөх зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч, байгаль орчин болон цахилгаан, дулааны холболттой холбоотой шалгууруудыг хянаж зөвшөөрлүүдийг батлаад байна. Эдгээр газар хөндөх зөвшөөрөл авсан талбайнуудад газар шорооны ажил явагдаж байх үед GPS багаж болон бусад программын тусламжтай нарийвчилсан хэмжилт хийж, хөндөгдсөн газрын хэмжээг газарзүйн мэдээллийн санд тухай бүр бүртгэж байна.

Батлагдсан 4 газар хөндөх зөвшөөрлийн талбайд урьдчилан шимт хөрсний хуулах гүнийг талбай тус бүрийн хөрсний хэв шинж болон хийгдэх ажилтай үйлдүүлэн MNS5916:2008. Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт стандартын дагуу 30-35см хуулж тухайн талбайд болон уурхайн шимт хөрсний овоолгод хадгалж байна.

Хүснэгт 3-2. Шимт хөрсний талбайнуудын мэдээлэл

| № | Байршил                             | Огноо      | Шимт хөрсний бүртгэл |                       |                                  | Газар хөндөх зөвшөөрлийн хуудас бөглөгдсөн эсэх | Тайлбар   |
|---|-------------------------------------|------------|----------------------|-----------------------|----------------------------------|---|---|
|   |                                     |            | Талбай               | Эзлэхүүн              | Шимт хөрс хадгалах талбай        |   |   |
| 1 | Уурхайн карьер                      | 2025.02.28 | 3.9 га               | 0 м <sup>3</sup>      | -                                | тийм  | Уулын ажил эхлүүлэх, хад чүлүү гүү жалга бүхий гадарга  |
| 2 | Замын ажил                          | 2025.03.06 | 3.3 га               | 6600 м <sup>3</sup>   | Замын ажлын хажууд хадгалах      | тийм  | Шимт хөрсийг 20-30 см-н зузаантай хуулсан.  |
| 3 | Баяжуулах үйлдвэр “Мак аранжин зэс” | 2025.03.15 | 0.37 га              | 600 м <sup>3</sup>    | МАЗ шимт хөрсний овоолийн талбай | тийм  | Шимт хөрсийг 20см зузаантай стандартын дагуу хуулж, хадгалж байна. Нуруулдан үүсгах овоолгын талбай |
| 4 | Уурхайн карьер                      | 2025.04.04 | 29 га                | 43,500 м <sup>3</sup> | Шимт хөрсний овоолго             | тийм  | Шимт хөрсний овоолго хийх талбай  |
| 5 | Уурхайн карьер                      | 2025.03.25 | 0.8 га               | 1600 м <sup>3</sup>   | Шимт хөрсний овоолго             | тийм  | Ил уурхайн ахилт  |
| 6 | Хаягдлын далангийн зам              | 2025.04.03 | 1.42 га              | 2840 м <sup>3</sup>   | Шимт хөрсний овоолго             | тийм  | Хаягдлын далангийн зам  |



Зураг 3-2. Шимт хөрс хуулах үеийн зураг

### 3.1.3 Шимт хөрсний овоолго

Төслийн хүрээнд шимт хөрсний овоолгыг бий болгох, тэдгээрийн байршил, эзлэхүүн хэмжээний бүртгэл, мэдээлийг тогтмол шинэчилдэг. Энэ ажилд уурхайн маркшейдерийн инженерүүдээс талбайн хэмжилтийг гүйцэтгэн, байгаль орчны хэсэгт өгч байна. 2025 онд уурхайн карьерт 3.9 га, замын ажилд 3.3 га, нуруулдан үүсгах талбайд 0.37га шимт хөрсний овоолго үүсгэхэд 29 га талбай шимт хөрсийг хуулсан байна. 2025 оны 10-р сарын байдлаар уурхайн шимт хөрсний овоолгын нийт талбай 29 га, өндөр 5м-с илүүгүй байна.

### 3.1.4 Шимт хөрсний хадгалалт

“Эрдэнэс Цагаан Суварга” ХХК нь хөрсөн бүрхэвчийг ариг гамтай, зөв зохистой ашиглах, цаашдын хэрэглээний тооцоог хянаж, хэмжээг нарийвчлан тодорхойлох зорилгоор хадгалсан хөрсний хэмжээ, эргүүлэн ашигласан хөрсний бүртгэлийг цаг тухай бүрд нь хийж байна.

2025 онд уурхайн ашиглалтын үйл ажиллагаа, барилгын ажлын үед хуулсан шимт хөрсийг овоолгод бүүлгаж, усанд автах, хог хаягдлаар бохирдохоос сэргийлэн цэвэрлэгээг тогтмол хийн, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.




Зураг 3-3. Овоолгуудыг тэмдэг тэмдэглэгээ

### 3.1.5 Шатах, тослох материалын асгаралтад хяналт тавих

#### 3.1.5.1 Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тайлагнах журам

“Эрдэнэс Цагаан Суварга” ХХК нь компанийн дотоод “Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах” журмыг 2024 онд батлуулан, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү журмын гол зорилго нь төслийн талбайн хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөл, аюул үүсгэж болзошгүй аливаа асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтын үед авах хариу арга хэмжээ болон хариуцах ажилчдыг тодорхой болгоход оршино. Төслийн ажилчид болон төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт байгууллагууд дараах үйл явцын зурaglалын дагуу асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тайлагнах арга хэмжээг хэрэгжүүлж байна.



Зураг 3-4. “Эрдэнэс Цагаан Суварга” ХХК-ийн асгаралтаас урьдчилан сэргийлэх, харуу арга хэмжээ авах, тайлагнах үйл явцын нарийвчилсан зураглал

Төслийн талбайд асгаралт үүссэн тохиолдолд анх илрүүлсэн ажилтан “Асгаралт мэдээлэх хуудас”-ын дагуу байгаль орчны мэргэжилтэн болон ХАБЭА-н мэргэжилтэнд яаралтай мэдээлж, тархалтыг хязгаарлаж, цэвэрлэх ажиллагааг журмын дагуу зохион байгуулж байна.

### ХАВСРАЛТ 1. АСГАРАЛТ МЭДЭЭЛЭХ ХУУДАС

| Асгаралт тохиолдсон огноо, цаг хугацаа<br>/ /            | Мэдээлсэн огноо, цаг хугацаа<br>/ /               |
|--|---|
| <b>Хариуцах хэсэг, нэгж</b>                              | <b>Асгарсан материал</b>                          |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Дизель түлш              |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Трансмисын шингэн        |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Бензин                   |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Хөдөлгүүрийн тос         |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Гидрийн тос              |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Хөргөлтийн шингэн        |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Трансматорын шингэн      |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Компрессорын тос         |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Товуд-өтгөн тос          |
| <input type="checkbox"/>                                 | <input type="checkbox"/> Бохир ус                 |
|  | <input type="checkbox"/> Бусад ..... (бичнэ үү)   |
| <b>Хэмжээ</b>  |   |
| Асгарсан хэмжээ  | литр  |
| Бохирдсон талбай   | м <sup>2</sup>                                    |
| <b>Асгаралтын байршил</b>                                | <b>Тоног төхөөрөмжийн нэр</b>                     |
|  |   |
| <b>Асгаралтын шалтгаан:</b>                              |   |
| <b>Хүний хүчин зүйл:</b>                                 | <b>Тоног төхөөрөмжийн хүчин зүйл:</b>             |
| <input type="checkbox"/> Хальсан                         | <input type="checkbox"/> Хязгаарлах хэсэг гэмтсэн |
| <input type="checkbox"/> Буруу багаж төхөөрөмж ашигласан | <input type="checkbox"/> Түгжээ эвдэрсэн          |
| <input type="checkbox"/> Багаж төхөөрөмж буруу ашигласан | <input type="checkbox"/> Ган хоолой, цуурсан      |
| <input type="checkbox"/> Сургалт муугаас                 | <input type="checkbox"/> Хоолой тасарсан, цоорсон |
| <input type="checkbox"/> Бусад                           | <input type="checkbox"/> Бусад                    |
| .....  | .....   |
| .....  | .....   |
| <b>Асгаралт болох хүртэлх үйл явдлыг тоочно</b>          |   |
|  |   |
| <b>Асгаралтыг хязгаарласан, цэвэрлэсэн арга</b>          |   |
|  |   |
| <b>Санал зөвлөмж</b>                                     |   |
|  |   |

Хүлээж авсан: /...../

Мэдээлсэн: /...../

Зураг 3-5. Асгаралт мэдээлэх хуудас

#### 3.1.5.2 Асгаралтын иж бүрдэл


Уурхайд баримталж буй дотоод журмын дагуу асгаралт үүсэж болзошгүй талбайнуудын ойролцоо асгаралтын үед ашиглах зорилготой асгаралтын иж бүрдлийг байрлуулдаг. Асгаралтын иж бүрдэл нь нүүрс-уст нэгдэл хөрс, гүний усыг бохирдуулахаас сэргийлж, өөртөө шингээж авч, цэвэрлэх зориулалттай иж бүрдлийг ашигладаг.



Зураг 3-6. Уурхайн талбайд байрлуулсан асгаралтын иж бүрдэл

### 3.1.6 Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариуй арга хэмжээ авах сургалт

Асгаралтын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх, асгаралтын үед авах арга хэмжээ, цэвэрлэх талаар нийт ажиллагсад ерөнхий “Аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-ны хүрээнд мэдлэг олгох зорилгоор тухайн хэсгийн ахлагч болон байгаль орчны мэргэжилтэн хамтран сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Түүнчлэн асгаралтын тохиолдол, туршлагад үндэслэн сургалтын агуулгыг тухайн хэсэг нэгжийн ажилчдад зориулж сэдэвчилсэн сургалт зохион байгуулсан.



Зураг 3-7. Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариуй арга хэмжээ авах сургалт

### 3.1.7 Тос, тослох материалын асгаралтаас урьдчилан сэргийлэх

Уурхайн талбайн хэмжээнд энгийн болон аюултай хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд дээр ангилан ялгалттай хогийн сав байршуулж, хогийн цэг дээр түр хадгалан эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлэн устгуулсан. Энгийн хог хаягдлыг тусгай талбайд салхи, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх эрсдлээс хамгаалан хадгалж байна.

### 3.1.8 Талбайн хяналт шалгалт

Асгаралт үүсч болзошгүй талбайд тогтмол хяналт тавьж ажилладаг бөгөөд үл тохирлыг гарсан тохиолдолд яаралтай хариу арга хэмжээг авдаг. Тайлант онд нэг удаа тос, тослох



### 3.2 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Цагаан суваргын зэс молибдены ордыг ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй 2 сөрөг нөлөөллийг бууруулах 7 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж бүрэн хэрэгжүүллээ.

Хүснэгт 3-3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд   | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Давтамж              | Зардал                 | Хэрэгжилт   |
|---|--|---|----------------------|------------------------|---|
| 1 |  | Усны тухай хүүлийн дагуу үс ашиглуулах зөвшөөрөл, дүгнэлтийг гаргуулж, сав газартай үс ашиглах гэрээ байгуулсаны үндсэн дээр усыг ашиглах   | I улирал             | Үйл ажиллагааны зардал | Усны газрын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн E-2504-000218 дугаар үс ашиглуулах дүгнэлтэд үндэслэн Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаанаас А/20 дугаартай үс ашиглах зөвшөөрлийг авч үс ашиглах гэрээ байгуулан ажилласан.  |
| 2 |  | Төслийн усны хэрэглээг сар бүр дотоод системд бүртгэх хянах   | Сар бүр              | Үйл ажиллагааны зардал | Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй усны хэрэглээг дотоод систем буюу ERP-д бүртгэн хяналт тавьж ажилладаг.   |
| 3 | Уурхайн үйл ажиллагаанд гүний үс ашиглах, усыг зөв зохистой ашиглаагүй тохиолдолд усны нөөцөд сөргөөр нөлөөлөх | Усан хангамжийн худгуудын тоолуурыг баталгаажуулалтыг сар бүр сумын байгаль орчны байцаагчаар хийлгэх, тоолуурын заалтаар байгалийн нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх. | Сар бүр              | 1,200,000              | Усан хангамжийн худгуудын тоолуурын баталгаажуулалтыг сар бүр сумын байгаль орчны байцаагчаар баталгаажуулан, тоолуурын заалтад үндэслэн байгалийн нөөц үс ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.  |
| 4 |  | Төслийн үйл ажиллагаатай холбоотой усны менежментийн журмын хэрэгжилтийг дагаж мөрдөн ажиллах   | Үйл ажиллагааны түрш | Үйл ажиллагааны зардал | “Монголын алт” ХХК-ийн ерөнхийлөгчийн 2022 оны 12-р сарын 02-ны өдрийн А/1223-р тушаалаар батлагдсан <i>Усны менежментийн журмыг</i> уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд дагаж мөрдөн ажиллаж байна. Уг журмаар төслийн үйл ажиллагааны үед усны нөөцийг эрэх, хайх, ашиглахтай холбоотой хүүлийн нийцлийг хангах, усны нөөцийг үр ашигтай зарцуулах, хэмнэх нөөц бололцоог нэмэгдүүлэх, усны нөөцийн хэмжээ ба чанарт хяналт, мониторинг хийх зорилгоор дагаж мөрддөг. |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд   | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Давтамж              | Зардал                                     | Хэрэгжилт   |
|---|--|---|----------------------|--|---|
| 5 |  | Ус дамжуулах шугам хоолойн ашиглалтад тогтмол хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд тухай бүр засах арга хэмжээ авах                                       | Үйл ажиллагааны түрш | Үйл ажиллагааны зардал                     | Ус дамжуулах хоолойн ашиглалтад тогтмол хяналт тавьж гэмтсэн тохиолдолд тухай бүр засах арга хэмжээ авч ажилласан. Гүний ус цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмж шинээр суурилуулан ашиглаж байна.   |
| 6 |  | Гадаргын ус цуглуулах цөөрмийг байгуулж, замын тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах   | Үйл ажиллагааны түрш | 5,000,000                                  | 2025 онд уурхайн олборлолт болон барилгын ажил явагдсан. Иймд гадаргын усыг дахин ашиглах зорилгоор үерийн ус цуглуулах цөөрмийг байгуулж, гадаргын усыг цуглуулаад байна. Энэхүү усыг 2025 онд барилгын ажил болон тоосжилтыг бууруулахад ашиглахаар төлөвлөж байна. |
| 7 |  | Дэлхийн усны өдрийг угтан ажилчдад усыг ариг гамтай ашиглах, усны хэрэглээг бууруулах тухай сургалт зохион байгуулах, усны өдрийг тэмдэглэн өнгөрөөх. | Жилд нэг удаа        | 2,500,000                                  | Дэлхийн усны өдрийг тохиолдуулан дэлхий нийтийн өмнө тулгамдаа буй цэвэр усны нөөцийн асуудлын талаар мэдээллийг багтаасан хананы самбарыг бэлтгэн нийт ажилчдад мэдлэг мэдээлэл түгээсэн.  |
| 8 |  | Усыг үр ашигтай хэрэглэх талаар үхүүлгэ, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самбарт шинэчилж тавих                                 | Үйл ажиллагааны түрш | 400,000                                    | Ус ашиглаж байгаа цэгүүдэд усыг арга гам ашиглах, усны цоргоор ус дусахыг хязгаардах үүднээс мэдээллийн хуудсыг байршуулан ажиллаж байна.   |
| 9 | Төслийн үйл ажиллагаа, ажилчдын санамсар болгоомжгүй үйл ажиллагаанаас орчны бохирдол үүсэх, газрын доорх усны чанарт нөлөөлөх | ОХШХ-ын дагуу гадаргын болон гүний усны бохирдлын мониторингийг хийх, ашиглах   | Улирал бүр           | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгах | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу гүний ус болон гадаргын усны мониторингийн ажлыг зохион байгуулж ажилласан. Усны химийн шинжилгээг тогтмол хийлгэдэг.   |

| №                       | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд   | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ  | Давтамж                | Зардал                 | Хэрэгжилт  |
|-------------------------|--|--|------------------------|------------------------|--|
| 10                      | Ахуйн бохир үс цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан тохиолдолд хөрсний бохирдол үүсэх, усны найрлага шинж чанарт сөргөөр нөлөөлөх | Ахуйн бохир үс цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих, шинжилгээ хийлгэх | Үйл ажиллагааны туршид | Үйл ажиллагааны зардал | Ахуйн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн болгох үүднээс төслийн талбайд ашиглагдаж буй цэвэрлэх байгууламжуудыг засварлахаар ажиллаж байна. Хаягдал усны дээжийг улирал бүр авч шинжлүүлсэн. Шинээр баригдаж буй ахуй бохир үс цэвэршүүлэх байгууламжийн барилгын ажил 70 хувьтай байна. |
| 11                      |  | Хаягдал усны дүгнэлтийг гаргуулж, үс бохирдуулсны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.         | Улирал бүр             |                        | 2025 оны хаягдал усны дүгнэлтийг улирал бүрээр гаргуулахаар хүсэлтийг ewater.mn оруулсан. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээг Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаатай байгуулж, хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг авсан.  |
| <b>Нийт зардал, төг</b> |  |  |                        |                        | <b>9,100,000</b>   |

### 3.2.1 Ус ашиглах гэрээ, дүгнэлт

Монгол улсын “Усны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т заасны дагуу 2024 оны 05-р сарын 28-ны өдөр 01 тоот ус ашиглуулах дүгнэлтийг Галба-Өөш-Долоодын Говийн сав газрын захиргаагаар гаргуулсан.

“Усны тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7 дахь заалт, 2.9 дүгээр зүйлийн 29.1-т заасны дагуу Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2025 оны 05-р сарын 26-ны өдрийн А/20 тоот тушаалыг үндэслэн 2025 оны 06-р сарын 17-ны өдөр 25/10 тоот ус ашиглах гэрээг байгуулсан.

Хүснэгт 3-4. Ус ашиглалтын зориулалт, хэмжээ

| Гэрээний дугаар | Эхлэх      | Дуусах     | Ус ашиглах зориулалт                   | Ашиглах усны хэмжээ           |
|-----------------|------------|------------|--|-------------------------------|
| 084-5125        | 2025.06.17 | 2025.12.31 | Эрчим хүчний үйлдвэрлэлд               | 94,802.96 м <sup>3</sup> /жил |
|                 |            |            | Барилга барилгын материал үйлдвэрлэхэд | 3,900 м <sup>3</sup> /жил     |
|                 |            |            | Шүүрлийн усны хэмжээ                   | 31,248 м <sup>3</sup> /жил    |
|                 |            |            | Унд ахуйн усны хэмжээ                  | 4,005 м <sup>3</sup> /жил     |

Төслийн хүрээнд 2025 оны 1-р сараас 10-р сар хүртэл тоолуурын заалтаар нийт 17743 м<sup>3</sup> ус ашигласан байна. Ус ашиглалтын хэмжээг сар бүр дотоод систем ERP-д оруулан бүртгэл мэдээллийг хөтөлсөн.

| * 2024                                    | 10000     | 15700  |       |
|---|-----------|--------|-------|
| 1 <input type="checkbox"/> Цагаан Суварга | 002-07-01 | Цагаан | 28200 |
| 2 <input type="checkbox"/> Цагаан Суварга | 002-08-01 | Цагаан | 23000 |
| 3 <input type="checkbox"/> Цагаан Суварга | 002-11-01 | Цагаан | 8200  |
| 4 <input type="checkbox"/> Цагаан Суварга | 002-11-01 | Цагаан | 8000  |
| 5 <input type="checkbox"/> Цагаан Суварга | 002-11-01 | Цагаан | 8000  |
| 6 <input type="checkbox"/> Цагаан Суварга | 002-11-01 | Цагаан | 1000  |
| 7 <input type="checkbox"/> Цагаан Суварга | 002-11-01 | Цагаан | 2000  |
| 8 <input type="checkbox"/> Цагаан Суварга | 002-09-01 | Цагаан | 28000 |

Зураг 3-10. Ус ашиглалтын мэдээг ERP системд хөтөлсөн байдал

Хүснэгт 3-5. Шүүрлийн ашиглалтын мэдээлэл

| Ус ашиглах зориулалт       | Ашигласан усны хэмжээ м <sup>3</sup> |
|----------------------------|--------------------------------------|
| Бетон зуурмаг үйлдвэрлэх   | 2640                                 |
| Ногоон байгууламж          | 3720                                 |
| Зам талбайн тоосжилт дарах | 11,760                               |
| <b>Нийт</b>                | <b>18,120</b>                        |

### 3.2.2 Усны тоолуур, ус ашигласны төлбөр

2024 оны 03-р сарын 21-ний өдөр төслийн усан хангамжийн 2 худагт Мандах сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнийг байлцуулан тоолуур сүүрилуулах акт үйлдүүлсэн.

Хүснэгт 3-6. Усан хангамжийн худгууд

| № | Худгуудын дугаар | Байршил     |              |
|---|------------------|-------------|--------------|
|   |                  | Өргөрөг     | Уртраг       |
| 1 | ЭЦ-09-21         | 44°00'05.9" | 108°26'03.6" |
| 2 | ЭЦ-09-16         | 44°00'19.1" | 108°26'44.6" |



Зураг 3-11. Усны тоолуур суурилууллт

Түүнчлэн усан хангамжийн худгуудын усны тоолууруудыг 2025 оны 04-р сарын 24-ны өдрөөс 2027 оны 04-р сарын 24-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаатайгаар Стандарт хэмжил зүйн газраар албан ёсоор баталгаажуулсан.

| СТАНДАРТ.<br>ХЭМЖИЛ ЗҮЙН<br>ГАЗАР   |                     | УСНЫ ТООЛУУРЫН<br>БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ |                       |
|---|---------------------|---|-----------------------|
|  |                     | № ЭУ .....244836                              |                       |
| Эрдэнэс цагаан суварга -д   |                     |   |                       |
| ашиглаж байгаа  | LXLС - 80           | загварын                                      | 40 м <sup>3</sup> /ц  |
| хэмжих хязгаартай,  | 80 мм-ийн голчтой № | 202304143                                     | -ын                   |
| халуун, хүйтэн усны тоолуурыг №   | 017                 | лацаар битүүмжилж                             |                       |
| (Доогуур зурах)   |                     |   |                       |
| 2027 оны  | 04 -р сарын         | 24  | -ны өдөр хүртэл улсын |
| баталгаажуулалтын гэрчилгээ олгов.  |                     |   |                       |
| Шалгалтын дараах заалт:   |                     | 300056 м <sup>3</sup>                         |                       |
| Лабораторийн тэмдэг   |                     | Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг           |                       |
| 2025 оны  | 04 -р сарын         | 24  | -ны өдөр              |

Зураг 3-12. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ

Ус ашигласны төлбөрийн хэмжээг усны эх үүсвэр дээр (худагт) байрлуулсан усны тоолуурын заалтын зөрүүг үндэслэн баталгаажуулж Мандах сумын байгаль орчны байцаагчаар 2025 оны 10-р сарын 15-ны өдөр хянуулсан.

2025 оны 10-р сарын байдлаар төслийн хэмжээнд ус ашигласны төлбөрт нийт 1,340,969 төгрөгийг төлөөд байна.





Зураг 3-15. Усны журмын нийт ажилдчын эрх, үүрэг

### 3.2.4 Ус дамжуулах хоолой засвар

Ус дамжуулах хоолойн ашиглалтад тогтмол хяналт тавьж гэмтсэн тохиолдолд тухай бүр засах арга хэмжээ авч ажилласан. Гүний үс цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмж шинээр суурилуулан ашиглаж байна. Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн гадна шугам хоолойн ажил 81.4 хувьтай явагдаж байна.



Зураг 3-16. Ус дамжуулах хоолойн шугам хоолойн ажлын үйл явц

Унд ахуйн ус цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмжийг суурилуулах ажлыг “Сөүт партс” ХХК-р хийж гүйцэтгүүлсэн.



Зураг 3-17. Унд ахуйн ус цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмж суурилуулах үйл явц

### 3.2.5 Гадаргын ус цуглуулах цөөрөм

Төслийн хүрээнд 2025 онд барилгын ажил болон тоосжилт дарахад усыг дахин ашиглах, гүний усны нөөцийг хэмнэх зорилгоор 2 талбайд ус хуримтлуулах цөөрмүүдийг ашигладаг. Тус 2 цөөрөм нь тус бүр 3 м гүнтэй, нийт 0.9 га, 27,000 м<sup>3</sup> гадаргын ус хуримтлуулах хүчин чадалтай.

*Хүснэгт 3-7. Үерийн цуглуулах цөөрмүүдийн ерөнхий мэдээлэл*

| № | Цөөрмийн нэр                      | Байршил                    | Талбайн хэмжээ | Ус хуримтлуулах хэмжээ |
|---|-----------------------------------|----------------------------|----------------|------------------------|
| 1 | Үерийн ус хуримтлуулах цөөрөм - 1 | 49 U 287315 UTM<br>4861865 | 0.6 га         | 18,000м <sup>3</sup>   |
|   |                                   | 49 U 287435 UTM<br>4861903 |                |                        |
|   |                                   | 49 U 287455 UTM<br>4861860 |                |                        |
|   |                                   | 49 U 287336 UTM<br>4861814 |                |                        |
| 2 | Үерийн ус хуримтлуулах цөөрөм - 2 | 49 U 287247 UTM<br>4862182 | 0.3 га         | 9,000м <sup>3</sup>    |
|   |                                   | 49 U 287184 UTM<br>4862170 |                |                        |
|   |                                   | 49 U 287201 UTM<br>4862121 |                |                        |
|   |                                   | 49 U 287253 UTM<br>4862142 |                |                        |




*Зураг 3-18. Үерийн ус хуримтлуулах цөөрөм-1*



### 3.2.7 Усны менежментийн сургалт

“Эрдэнэс Цагаан Суварга” ХХК нь нийт ажилчдын болон төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт байгууллагуудын ажилчдын байгаль орчны мэдлэгийг дээшлүүлж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангах үүднээс мэдлэг олгох сургалтыг тогтмол давтамжтай зохион байгуулж байна.



Зураг 3-21. Усны менежментийн сургалтын материалууд

Түүнчлэн уурхайн хэмжээнд усаа хэмнэх үриалга, усны алдагдалаас урьдчилан сэргийлэх зорилгоор доорх зурагт хуудсуудыг хэвлэж талбайн хэмжээнд шаардлагатай газруудад байрлуулсан.



Зураг 3-22. Усаа хэмнэх зурагт хуудас

### 3.2.8 Гүний усны мониторинг

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу гүний ус болон гадаргын усны мониторингийн ажлыг зохион байгуулж ажилласан. Усны химийн шинжилгээг тогтмол хийлгэдэг. /Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс үзнэ үү./




### 3.2.9 Бохир ус цэвэрлэх байгууламж

Төслийн талбайд 2025 оны байдлаар нийт 2 ширхэг ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж ажиллаж байгаа бөгөөд нийт хүчин чадал нь 150м<sup>3</sup> (800 хүн/өдөр) байна. Эдгээр цэвэрлэх байгууламжаас гарсан усыг Дорноговь аймгийн Мандах сумын засаг даргын 2013 оны 12-р сарын 23-ны өдрийн А/149 дугаар “Хаягдал ус зайлуулах цэгийн байршил тогтоох тухай” захирамжын дагуу зайлуулж байна.

Хүснэгт 3-8. Цэвэрлэх байгууламжийн ерөнхий мэдээлэл

| № | Бохир ус цэвэрлэх байгууламж                 | Хүчин чадал             | Технологи                                   | Үйлдвэрлэгч                                    |
|---|--|-------------------------|---|--|
| 1 | Гал тогооны бохир ус цэвэрлэх байгууламж     | 75 м <sup>3</sup> /өдөр | Механик болон биологийн аргаар цэвэршүүлнэ. | Jiangsu Jinyi Water Industry Equipment Co.,Ltd |
| 2 | Ажилчдын байрны бохир ус цэвэрлэх байгууламж | 75 м <sup>3</sup> /өдөр |   |  |

Бохир ус цэвэрлэх байгууламж нь үндсэн 2 танкнаас бүрдэх бөгөөд эхний танк буюу хүчилтөрөгчийн танк нь биофилмэд суурилсан биологийн цэвэрлэгээг хийнэ. Хүчилтөрөгчийн танкнаас гарах хаягдал нь хоёрдогч тунгаагуурлуу орох бөгөөд босоо үрсгалтай бүтэцтэй байна.



Зураг 3-23. Бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл

Төслийн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа сайжруулахаар мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээг авч зөвлөмжийг шат дараатайгаар хэрэгжүүлж байна. Зөвлөх үйлчилгээний хүрээнд 3 сонголт бүхий сайжруулах зөвлөмж гаргасан Үүнд:

- Сонголт 1. Одоо байгаа сонгодог идэвхжүүлсэн лагийн аргаар цэвэрлэх технологит өөрчлөлт оруулахгүйгээр зайлшгүй хийж гүйцэтгэх шаардлагатай засвар үйлчилгээ болон ашиглалт талаас арга хэмжээ авах.
- Сонголт 2. Дээр дурдсан буюу сонголт 1-ийн засвар үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсний дараа ЦБ-ийн тогтворжуулах танканд сараалж угсарсны дараагаас тогтворжуулах танканд нэмэлтээр агааржуулалтын систем бүхий шугаман диффузорын угсралт хийх.
- Сонголт 3. АБУЦБ-ийн сонгодог идэвхжүүлсэн лагийн аргаар цэвэрлэх технологи буюу “Classic activated sludge”-ийг “Sequencing Batch Reactor” буюу багц дараалсан реакторын аргаар цэвэрлэх технологируу шижлүүлэн угсралт хийх.

Түүнчлэн манай төслийн хувьд шинэ цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа тул эхний сонголт буюу одоо байгаа тоног төхөөрөмжийг сайжруулах сонголтыг

сонгож үүний хүрээнд төлөвлөгөө боловсруулсан бөгөөд нэмэлтээр дотоодоо судалгаа хийсэн. Тус судалгаагаар цэвэрлэх байгууламжийн технологи, үйл ажиллагаа нь “MNS 6561:2015” болон “MNS 4943:2015” үндэсний стандартыг бүрэн хангах шаардлагатай бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд SBR (Sequencing Batch Reactor) + UF (Ultrafiltration) + UV (Ultraviolet Disinfection) гэсэн гурван үе шаттай дэвшилтэт цэвэрлэгээний технологи хамгийн оновчтой гэж үзсэн тиймээс бид зөвөлгөө болон дотоодоо хийсэн судалгааг харгалзан үзээд ахуйн бохир үс цэвэрлэх байгууламжийг засвар үйлчилгээг хийлгэхээр болж ажлын даалгавар боловсруулан гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын зохион байгуулж байна.



Зураг 3-24. Шинээр баригдаж буй цэвэрлэх байгууламж

Энэхүү төхөөрөмж нь ахуйн болон үйлдвэрийн гаралтай бохир усыг цэвэрлэх зориулалттай интеллектуаль биореактор (Intelligent Bioreactor) бөгөөд өдөрт 250 тонн хүртэл бохир үс боловсруулах хүчин чадалтай. Төхөөрөмжийн нийт цахилгаан хэрэглээ нь AC380V, 26.0 кВт, дундаж эрчим хүчний зарцуулалт 1.5–2.0 кВт-ц/м<sup>3</sup> байх юм. Цэвэрлэгээний процесс бүрэн автомат удирдлагатай бөгөөд бохир усны оролт, агааржуулалт, шүүлтүүрийн ажиллах мөчлөг болон лагийн ялгалт зэрэг ажиллагаа нь хянах самбараар дамжуулан автомат болон гар удирдлагын горимоор ажиллана.

Систем нь урьдчилсан шүүлтүүр, анаэроб–аэроб реактор, MBR мембран шүүлтүүр, ариутгалын нэгж гэсэн үндсэн дөрвөн үе шатаас бүрдэнэ. Ариутгалын шатанд натрийн гипохлорит эсвэл хэт ягаан туяаны (UV) гэрэл ашиглан үлдэгдэл нян, вирусийг 99.9%-иар устгах бөгөөд ингэснээр гарч буй ус “MNS 4943:2015” стандартыг хангах юм.

### 3.2.10 Хаягдал усны дүгнэлт

2024 оны E-2504-000399 дугаартай хаягдал усны дүгнэлтийг “Усны газар”-р гаргуулж ус бохирдуулсны төлбөр болох 2,852,590 төг татварын санд төвлөрүүлсэн байна. Ахуйн бохир үс цэвэрлэх байгууламжууд нь 2 шатлал бүхий механик болон биологийн аргаар цэвэрлэдэг бөгөөд эцсийн бүтээгдэхүүн нь цэвэрлэсэн ус болон тунаж үлдэх лаг байдаг.

Цэвэрлэсэн бохир усны дээжлэлтийг 1-10 сарын хооронд гүйцэтгэж лабораторийн шинжилгээнд явуулж, тогтмол хяналт тавьж байна. (Дэлгэрэнгүйг ОХШХ-ийн биелэлт бүлгээс үзнэ үү.) Түүнчлэн тайлант онд цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хийхээр “Хаанзаа сервис” ХХК-ийн мэргэжилтнүүд төслийн талбай дээр ажилласан.

2025 оны 06-р сарын 03-ны өдөр Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаагаар 0162-5125 дугаар тоот “Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ” байгуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал”-ыг тус тус үндэслэн тооцож хаягдал усны 2,852,590 төг төлбөрийг төлсөн

**БАТЛАВ**  
ГЭЛБЭ-ӨМӨД ДӨЛӨӨДӨН ГОВИЙН САВТАРЫН ЗАСАГСААРЫН ДАГАА Б.ЯЛБАТБАГЦ

**БАТЛАВ**  
“ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА” ХХК-ИЙН ГҮВЧЛЭГЦЭЭ ХАИРГАЛ

**ХАИРГАЛ УСНЫ БАЙГАЛЬД ШУУД НЭЙЛҮҮЛЭХ БАЙГАА АА ХУУЛИЙН ЭГТЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

2025 оны 05 сарын 13 ны өдөр

Д. Арнуулбаатар  
Харгалд усны бохирдуулсны төлбөрийн гэрээ

Сайнханд сум

Усны тухай хуулийн 24 дугаар зүйл, 24.2 дая хэсэгт заасны дагуу Усны тухай 2025 оны 05 дугаар сарын 02 ны өдрийн Е.2504-000389 дугаартай дүгээлт, Гэлбэ-Өмөд Дөлдөдөн говийн сав газрын зохиогчийн дүрэм 2025 оны 08 дугаар сарын 03 ны өдрийн хяналдаг ус хянг, хайгуулын зохиогчийн үндэслэл:

Нэг талаас ус ашиглуулагчийн талаас Гэлбэ-Өмөд Дөлдөдөн говийн сав газрын зохиогчийн Усны барилга байгууламж, үндэср, нэгдэл нь хууль эр зэмлэгийн агуудал заруудан мөргөмтэй О.Жамцдорж нэрээ талаас ус бохирдуулгачий талаас Дорноговь аймгийн Мандах сумд байрлах “Эрдэнэс Цагаан Суварга” ХХК улсын бүртгэлийн дугаар 9011400103, регистрийн дугаар 95245201 айм Ус нийлүүлэлтийн ажил хийгчээр О.Жамц нар ус бохирдуулсны төлбөр, мөнгө талбар чөлөөт хөндөг төлбөрийн төлбөрийн гэрээ 1 жил хугацааг эргэлтэй байгуулна.

**Хайр. Гэрээний гол нөхцөл**

2.1. Ус бохирдуулгач нь хяналдаг усны Хэрэгсэл байгаа орчмо. Усны чанар, Хяналдаг ус, Ерөнхий зохиогчийн МНО, 4843.7075 өмчөөрчлөх нэрлэлт хяналдагчид нийлүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулгач нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дая хэсэгт заасны дагуу хяналдаг усны чанарыг энэүү гэрээний 2.1-д заасан стандартын норматын шаардлагад нийлүүлсэн тооцогдоног. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6.1.1 заасны дагуу хяналдаг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хамгаалагч төлбөрийн чөлөөт, стандартын норматын шаардлагад нийлүүлэгчий талаас хяналдагч ус бохирдуулсны мөнгө төлбөрийг хяналдаг уснд агуулахад бохирдуулах бодисын хэмжээгээс хамгаан 2-5 дахин шалтан өсгөж халбарар тооцож тална.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дая хэсэгт заасны дагуу хяналдаг усны дая бохирдуулсны бодист нэгдэх төлбөр, мөнгө төлбөрийг дараа үндэслэл зөвхөн сарын 20 ны өдрийг дотор зарчмалах татаарын албад тална.

2.4. Ус бохирдуулгач нь дараа нэрлэлтийг угирал тунд Сав газрын зохиогчид, марла татаарын албад агуулуулна. Тунд

2.4.1. Хяналдаг ус нийлүүлдэг ус, хуулийн этгээдийн нэр;

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөвхөн мөнгөд нийлүүлсэн хяналдаг усны хэмжээ;

2.4.3. Байгальд нийлүүлсэн хяналдаг усны хэмжээ;

2.3. Энэүү гэрээ гүйцэт, дуусажар болгох, хүмүүг болгохой хяналдагчид агуулах 2 тал хяналдаг төлбөрийг үндэслэлээр хяналдагчид.

2.4. Энэүү гэрээг хяналдагчид сарын ажил хийгчээр мөнгө төлбөрийн мөнгө хуульээр хяналдагчид эргэлтэй төлбөр эс төлбөрийн мөнгө хуульээр хяналдагчид.

**Зургаа. Давардагчгүй хүчин туйл**

3.1. Ус бохирдуулгач нь давардагчгүй хүчин туйл Гэрээний гэрээ хийгчид, угр тал туйл, хар савны, хяналдаг усны гэрээ болон байгалийн бусад агууд үндэслэл, мөнгө мөнгө гэрээ мөнгө байгалийн улмаас гэрээгээр хуульээр үүрэг биелүүлж болгохгүй болгох төлбөрийг гэрээний мөнгө мөнгө мөнгө мөнгө, торуулыг чөлөөтөд агуудал болно.

3.2. Ус бохирдуулгач нь давардагчгүй хүчин туйл бай болгох мөнгө

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**Ус ашигчид үйлдэгч төлбөрийг:**  
Гэлбэ-Өмөд Дөлдөдөн говийн сав газрын зохиогчид  
Усны барилга байгууламж, үндэср, нэгдэл нь хууль эр зэмлэгийн агуудал заруудан мөргөмтэй

**Ус ашигчид төлбөрийг:**  
“Эрдэнэс Цагаан Суварга” ХХК-ийн Ус нийлүүлэлтийн ажил хийгчээр

Хайр: Дорноговь айм, Сайнханд сум, 3-р Савын ажил албаны 1 өмчөөр  
Харгалд усны (876) - 9160432, 9054433

Хайр: Улаанбаатар хот, Хан-Уул дугаар, 1-р хороо, 10-р хороолол, Чингэлтэй аргын тал, “Монголын Алт” ХХК-ийн тас Сав-44  
Харгалд усны: 8907690

Зураг 3-25. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ

| ГОЛОМТ БАНК<br>Сав ажил хийгчээр  |   | Пахим гүйлгээний баримт   |                                     |
|---|---|---|-------------------------------------|
| Бусадгүйн төлбөр дугаар: 340101338                                      |   | Талаа өгсөө: 2025-09-27 08:27   |                                     |
| Шанхуулын үнэ дүгээлт дугаар: <b>0140000215</b><br>MNT75002500014000215 | Хэргийн шалтгаан код: <b>1165117377</b>             | Түний мөнгө дүн: <b>2,852,390.27 MNT</b>  | Гүйцэтгэлийн төлөм: <b>Ажилтгай</b> |
| Шанхуулын үнэ нэр: <b>ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА ХХК</b>                    | Хэргийн шалтгаан нэр: <b>ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР</b> | Түний мөнгө үнэ: <b>1250602336073,64101400182,5824826,64101400182,900292508</b> |                                     |
|   | Хэргийн шалтгаан дая: <b>2025-06-26</b>             | Түний мөнгө өгсөө: <b>2025-06-26</b>  |                                     |
| Гүйцэтгэлийн мөнгө хэрэгсэл: <b>С. Ахүү</b>                             | Гүйцэтгэлийн мөнгө хэрэгсэл: <b>Д. Арнуулбаатар</b> | Гүйцэтгэлийн мөнгө хэрэгсэл: <b>Г. ЦОГТ</b>                                     |                                     |

Ус үүрэгээр хяналдагчид О. Голломт Банк ХК

Зураг 3-26. Хяналдаг усны төлбөрийн баримт

### 3.3 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ


Цагаан суваргын зэс молибдены ордыг ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд ургамлын нөмрөгт үүсгэж болзошгүй 3 сөрөг нөлөөллийг бууруулах 4 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд ажлуудыг 100% хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 3-9. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

| №                       | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд   | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ   | Давтамж              | Зардал  | Хэрэгжилт  |
|-------------------------|--|---|----------------------|---|--|
| 1                       | Уурхайн үйл ажиллагаанаас газрын гадарга эвдрэлд өртөж, ургамлан нөмрөг устана дарагдана.                  | Төслийн дотоод талбайн ургамалжилтийн мэдээг цуглуулах, гео мэдээллийн санд бүртгэх, архив үүсгэх   | 3-р улирлаас эхлэн   | Үйл ажиллагааны зардал                        | 6 цэгт ургамлын мониторингийн хэмжилт хийж, хэмжилтийн үр дүнд түлгуурлан Газарзүйн мэдээллийн системийн суурь мэдээллийн бааз (Geodatabase)-ыг үүсгэн боловсрууллаа. (Дэлгэрэнгүйг 3.3.1-с үзнэ үү)   |
| 2                       | Ургамлан нөмрөг устана дарагдана.  | Уурхайн олборлолтын талбай, түр зам, ажилчдын кемп зэрэг газруудад ургамлан нөмрөгийн хяналт мониторингийг тогтсон хуваарийн дагуу хийх, хэмжилтийн үр дүнг хянах | 8-р сард             | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд ургамлан нөмрөгийн хяналт мониторингийн ажлыг 6 цэгт зохион байгуулж бичиглэл хийсэн. (Дэлгэрэнгүйг 3.3.2-с үзнэ үү)   |
| 3                       | Ургамлан нөмрөг уурхайн дэд бүтцийн барилга байгууламж, овоолгын доор дарагдана.                           | Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэн дэмжин ажиллах, ногоон байгууламжийг арчлах, нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлэх    | Үйл ажиллагааны түрш | Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.     | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 5-р сарын 10 нд Мандах сумтай хамтран Мандах төгөлд 300 ш модыг орон нутгийн иргэдтэй хамтран тарив. Намрын мод тарих ажлын хүрээнд төслийн талбайд 350 ш хайлаас модыг тарьсан. (Дэлгэрэнгүйг 3.3.3-с үзнэ үү)  |
| 4                       | Машин техникт эвдрэл гэмтэл гарч шатах тослох материал асгарах улмаар ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй. | Тээврийн хэрэгслүүдийн техник үйлчилгээг цаг тухайд нь зориулалтын хатуу хүчилттай талбайд хийх, ажилчдад сургалт орох, ойлголт өгөх                              | Үйл ажиллагааны түрш | Хөрөнгө оруулалтын зардал                     | Төслийн талбайд үйл ажиллагаа явуулж байгаа үндсэн, гэрээт, туслан гүйцэтгэгч компаний ЗҮТ-ийн ажилчдад Тээврийн хэрэгслүүдийн техник үйлчилгээг цаг тухайд нь зориулалтын хатуу хүчилттай талбайд хийж байхыг зааварчилж мөн тос тослох материалын асгаралтын дотоод журмыг шинэчлэн батлуулан дагаж мөрдөж байна. (Дэлгэрэнгүйг 3.3.4-с үзнэ үү) |
| <b>Нийт зардал, төг</b> |  |   |                      |   |  |

### 3.3.1 Ургамалжилтын мэдээг цуглуулах

Тайлант онд төслийн талбайд ургамлын вегетацийн үеэр 6 цэгт ургамлын мониторингийн хэмжилт хийж, хэмжилтийн үр дүнд тулгуурлан Газарзүйн мэдээллийн системийн суурь мэдээллийн бааз (Geodatabase)-ыг үүсгэн боловсрууллаа. Энэхүү ажил нь төслийн талбайн экосистемийн төлөв байдлыг тогтоох, ургамлын бүрхэц, талхагдал, төрөл зүйлийн бүрэлдэхүүн, ургамлын бүрхэлтийн хувь зэрэг үзүүлэлтийг орон зайн мэдээлэлтэй уялдуулан бүртгэх зорилготой байв.



Зураг 3-27. Төслийн талбайд хийсэн ургамлын бүртгэл

#### Үр дүн, ажиглалт

Ургамлын мониторингийн хүрээнд нийт зургаан цэгт хэмжилт хийснээс, дөрвөн цэгт ургамлын бүрхэц 30–40 хувьтай, хоёр цэгт 10–15 хувийн бүрхэцтэй байв. Халцгай газрын эзлэх хувь 0–90 хувь хооронд хэлбэлзэж, Кемпийн орчим болон уурхайн бүсэд ургамлын бүрхэц харьцангуй сайн, харин хөрсний овоолгын бүсэд ургамлын бүрхэц сийрэг байгааг тогтоов. Талхагдал зөвхөн НҮ кемпийн зүүн талын цэгт 60 хувийн хэмжээнд ажиглагдсан.

Хэмжилтийн үр дүнд нийт долоон зүйл ургамал бүртгэгдсэн бөгөөд хамгийн өргөн тархалттай зүйл нь Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*) болон Шарилж (*Artemisia sp.*) байв. Судалгааны дүнгээс харахад төслийн талбай нь хуурай, тал хээрийн экосистемийн төлөөлөл бүхий ургамлын нөмрөг зонхилсон, харьцангуй бага төрөл зүйлийн бүрэлдэхүүнтэй, ургамлын олон янз байдал доогуур түвшинд байна.

### 3.3.2 Ургамлын мониторинг

Төслийн талбайн ургамлын аймаг, ургамалжилтын судалгааг 8-р сард буюу ургамлын вегетацийн хугацаанд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан 6 цэгт ургамалжилтын бичиглэл үйлдсэн.


Хүснэгт 3-10. Төслийн хөрсний хяналт мониторингийн цэгүүдийн мэдээлэл

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр        | Цэгийн координат        | Дээж авсан цэгийн тодорхойлолт                      |
|---|---------------|-------------------|-------------------------|---|
| 1 | TS_P_1        | НҮ кемп зүүн талд | 49 U 287332 UTM 4862473 | Төслийн үйл ажиллагаанаас ургамалд үзүүлж буй сөрөг |

|   |        |                             |                         |   |
|---|--------|-----------------------------|-------------------------|---|
| 2 | TS_P_2 | Хөрсний овоолго баруун талд | 49 U 282252 UTM 4860148 | нөлөөллийг үнэлэх, төслийн талбайн ойр орчмын ургамалжилтыг бүртгэж дата мэдээлэл үүсгэх ач холбогдолтой. |
| 3 | TS_P_3 | Дэд станцаас баруун талд    | 49 U 285769 UTM 4862079 |   |
| 4 | TS_P_4 | Уурхайн орчим               | 49 U 286269 UTM 4860134 |   |
| 5 | TS_P_5 | Хогийн цэгээс зүүн хойш     | 49 U 288121 UTM 4859888 |   |
| 6 | TS_P_6 | Кемп                        | 49 U 286539 UTM 4862446 |   |

Хүснэгт 3-11. Ургамлын хяналт, мониторингийн цэгүүд

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр                  | Ургамалжилтын зураг  |
|---|---------------|-----------------------------|--|
| 1 | TS_P_1        | НҮ кемп зүүн талд           |    |
| 2 | TS_P_2        | Хөрсний овоолго баруун талд |   |
| 3 | TS_P_3        | Дэд станцаас баруун талд    |  |

|   |        |                         |   |
|---|--------|-------------------------|---|
| 4 | TS_P_4 | Уурхайн орчим           |   |
| 5 | TS_P_5 | Хогийн цэгээс зүүн хойш |   |
| 6 | TS_P_6 | Кемп                    |  |





Зураг 3-28. Ургамлын хяналт мониторингийн үйл явц

### 3.3.3 Ногоон байгууламжийн арчилгаа, тордолгоо

Эрдэнэ цагаан суварга уурхай нь Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэн ногоон байгууламжийг арчлах, нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд “Эрдэнэс Цагаан Суварга” ХХК нь 5-р сарын 10нд буюу Үндэсний мод тарих өдөрлөгийн хүрээнд Дорноговь аймгийн ЗДТГ болон Ерөнхий боловсролын сургуультай хамтран тэмдэглэн өнгөрүүлэв. Тус арга хэмжээний хүрээнд Мандах сумын “Мандах” төгөлд Гацуур, Арц, хайлаас зэрэг 300 модыг сургуулийн багачуудтай хамтран тарьсан тус арга хэмжээний үеэр сумын Ерөнхий боловсролын 8-9-р ангийн хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулж анги тус бүр шагналт байрыг шалгаруулж гарын бэлэг, өргөмжлөлөөр урамшуулав.



Зураг 3-29. Мандах сумын мандах төгөл



Зураг 3-30. Арга хэмжээний үеэр тарьсан мод болон бордоо



*Зураг 3-31. Мод тарих арга хэмжээнд оролцсон 8-9 ангийн сурагчид*



*Зураг 3-32. Мод тарих аргазүй зөвлөмж өгч буй байдал*

Тус арга хэмжээний үер 8-9 ангийн 40 хүүхэд оролцосон бөгөөд сургуулийн нийгмийн ажилтан сурагчдыг зохион байгуулж мөн сурагчид болон мод тарьж буй иргэдийг мод тарих зөвлөмж, аргазүйгээр “Мандах” төгөл хариуцагч С. Сайханжаргал хангаж бидний ажилд дэмжлэг үзүүлсэн юм.



Зураг 3-33. Мод тарих үйл ажиллагаа



*Зураг 3-34. Гар зургийн уралдаанд шалгарсан хүүхдүүдэд шагнал гардуулах үйл явц*

Мөн энэхүү Тэрбум мод арга хэмжээний үер тус үйл мод тарихад оролцосон бүх сурагчдад байгууллагын гарын бэлгийг гардуулж сумын ерөнхий боловсролын сурагчдын дунд зарласан гар зургийн уралдааны шагнал, урамшуулалыг гардуулсан юм.



*Зураг 3-35. Мод тарих арга хэмжээнд оролцогсад*

### 3.3.4 Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ

Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний явцад тос тослох материалын асгаралт үүсэж хөрсөнд нэвчих нь ургамлын үндэсний өсөлт, түүнчлэн ургацын чанарт сөргөөр нөлөөлөх тул уурхай хэмжээнд техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг зориулалтын хатуу хүчилттай талбайд хийж байгаа эсэхэд хяналт тавих, асгаралтыг бүртгэлжүүлэх, ажилчдад зааварчилгаа

сургалт орох түүнчлэн тос тослох материалын асгаралтын дотоод журмыг боловсруулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.



Зураг 3-36. Засвар үйлчилгээний төв



Зураг 3-37. Шатах тослох материалын захистой хэрэглээний талаарх сургалт



Зураг 3-38. ЗҮТ-ийн засварын хатуу хучилтай талбай

### 3.4 АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Цагаан суваргын зэс молибдены ордыг ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлж болзошгүй 5 сөрөг нөлөөллийг бууруулах 10 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж бүрэн хэрэгжүүллээ. Түүнчлэн тус тусад нь төлөвлөсөн зарим сургалт, үхүүлгын ажлыг нэгтгэн хүргэв.

Хүснэгт 3-12 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд   | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ  | Хэрэгжилт   |
|---|--|--|---|
| 1 | Хууль бус ан агнуур хийх, амьтны аймгийн популяцад сөргөөр нөлөөлөх  | Ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад хяналт тавих, сургалт үхүүлга явуулах,  | Нийт ажилчдад хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх мэдлэг мэдээлэл олгох сургалтын олгодог. (Дэлгэрэнгүйг 3.5.1-с үзнэ үү.)   |
| 2 |  | Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай компанийн дотоод журмыг боловсруулан хэрэгжүүлэх   | Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох дотоод журмыг боловсруулсан. (Дэлгэрэнгүйг 3.5.2-с үзнэ үү.)  |
| 3 | Шимт хөрсний хуулалтаар мэрэгчид, мөлхөгчид гэх мэт сээр нуруутан амьтдын амьдрах орчныг сүйтгэх                                 | Төслийн талбайн ойр орчимд амьтны үзэгдэлийг тогтмол бүртгэлжүүлж дата мэдээлэл үүсгэх, шаардлагагүй тохиолдолд зөвшөөрөлгүй газар хөндөхгүй байх, Газар хөндөх зөвшөөрлийн дагуу хөндөгдөх газар үнэлгээ хийж ховор амьтан, ургамал бүртгэгдээгүй тохиолдолд газар хөндөлт хийхгүй байх | Газар шорооны ажлыг эхлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл үйлдэж, хөндөгдсөн талбайн мэдээллийг бүртгэлжүүлэн архилаж байна. (Дэлгэрэнгүйг 3.5.3-с үзнэ үү.)   |
| 4 | Хаягдлын цөөрмийг стандарт журмын дагуу нөхөн сэргээгүй эсвэл хашаалж, тэмдэгжүүлээгүй орхисон тохиолдолд мал амьтан унаж эрсдэх | Хаягдлын сан, усан санд мал амьтан орохоос хамгаалах, үйл ажиллагааны түршид хяналт тавих  | Уурхайн төслийн талбайд хаягдлын сан 2, усан сан 2 байгаа бөгөөд эдгээрт зэрлэг ан амьтан орж үхэхээс сэргийлж 7 хоног 1-2 удаа тогтмол хяналт тавьж байна. (Дэлгэрэнгүйг 3.5.4-с үзнэ үү.)   |
| 5 | Хууль бус ан агнуур хийх, амьтны аймгийн популяцад сөргөөр нөлөөлөх  | Ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад хяналт тавих, сургалт үхүүлга явуулах, ан амьтан агнасан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх  | Нийт ажилчдад хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх мэдлэг мэдээлэл олгох сургалтын зохион байгуулан ажиллав. Түүнчлэн энэхүү сургалтыг 3.5.1-т тусгасан сургалттай нэгтгэн зохион байгуулав. (Дэлгэрэнгүйг 3.5.1-с үзнэ үү) |

| №  | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд  | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ  | Хэрэгжилт  |
|----|---|--|--|
| 6  | Уурхайн үйл ажиллагааны улмаас зэрлэг амьтдын амьдрах орчин доройтох, идэш тэжээлийн хомсдол үүсэх. | Амьтны үзэгдэл зүйд ажиглалт хийх, бүртгэл мэдээлэл хөтлөх   | <ul style="list-style-type: none"> <li>Төслийн талбайн ойр орчимд амьтны үзэгдлийг компанийн дотоод системдээ тогтмол бүртгэх</li> <li>Ан амьтны талаарх мэдээллийг байгаль орчны мэргэжилтэнд мэдэгдэх талаар мэдээллийн самбарыг нүдэнд харагдах газар байршуулах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. (Дэлгэрэнгүйг 3.5.5-с үзнэ үү.)</li> </ul> |
| 7  |   | Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгүй, нүх оромжийн ойролцоо анхааруулсан тэмдгүүд байрлуулах, уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар анхааруулга сануулга өгөх | Төслийн талбай мөн Нарангийн бүлгийн орчимд зэрлэг ан амьтан олноор идээшлэдэг тул дээр дурьдсан цэгүүдэд техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар анхааруулга сануулга өгч тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. (Дэлгэрэнгүйг 3.5.6-с үзнэ үү.)   |
| 8  |   | Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ойр орчмын буюу нөлөөллийн бүсийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын ан амьтдыг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх   | Зуншлага сайхан байсан тул өвс тэжээл тавих шаардлага гараагүй.  |
| 9  |   | Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар   | Нийт ажилчдад хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх мэдлэг мэдээлэл олгох сургалтын зохион байгуулан ажиллав. Түүнчлэн энэхүү сургалтыг 3.5.1-т тусгасан сургалттай нэгтгэн зохион байгуулав. (Дэлгэрэнгүйг 3.5.1-с үзнэ үү)  |
| 10 |   | МУ-ын улаан ном, бүс нутгийн болон ОУ-ын улаан данс (IUCN), бусад хууль тогтоомж, гэрээ конвенциор хамгаалагдсан ховор, нэн ховор зэрлэг амьтдын талаар сургалт зохион байгуулах   | Нийт ажилчдад хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх мэдлэг мэдээлэл олгох сургалтын зохион байгуулан ажиллав. Түүнчлэн энэхүү сургалтыг 3.5.1-т тусгасан сургалттай нэгтгэн зохион байгуулав. (Дэлгэрэнгүйг 3.5.1-с үзнэ үү)  |

### 3.4.1 Мэдлэг, мэдээлэл олгох сургалт

Нийт ажилчдад ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зүлзага, үүр өндгийг сүйтгэхгүй байх талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтыг орж байна.



Зураг 3-39. Зэрлэг ан амьтдын талаарх мэдлэг олгох сургалт



Зураг 3-40. Зэрлэг ан амьтдын бүртгэл илгээх заавар


### 3.4.2 Ан амьтан хамгааллын арга хэмжээ

ЭЦС ХХК-ийн Цагаан Суваргын төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны хүрээнд төслийн талбайд Үндсэн болон гадаад, дотоодын гэрээт байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Үүнтэй холбоотой төслийн талбайд ажиллаж буй ажилчид ургамал, амьтанд зөвшөөрөлгүй хүрэх, сүйтэх, түүх зэрэг эрсдлүүд гарах боломжтой юм. Түүнчлэн ургамал, амьтдад үзүүлэх нөлөөллийг судлан тогтоох, тэдгээрийг хамгаалах, төслийн үйл ажиллагааны хүрээнд хууль бусаар ан амьтан агнах, ховор нэн ховор ургамал түүх, тээвэрлэх, ашиглахыг хориглох, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, ажилчдын үүрэг, хариуцлагыг тодорхойлох зорилгоор . зорилгоор "Ан амьтан, ургамлын мэдээллийг бүртгэх, хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тээвэрлэх, ашиглахыг хориглох журам"-ыг боловсруулсан хэрэгжүүлж байна.



бага хэмжээнд хязгаарлах, хянах, бүртгэх зорилгоор газар хөндөх зөвшөөрлийн хуудас болон шимт хөрсний бүртгэлийн хуудсын дагуу хүсэлтүүдийг хүлээн авч, шийдвэрлэдэг.

|  |  |  |  |
|--|--|--|--|
|  |  |  |  |
|  |  |  |  |
|  |  |  |  |
|  |  |  |  |



Зураг 3-42. Газар хөндөгдөхөөс өмнө хийгдсэн газар хөндөлтийн зөвшөөрлийн маягт

2025 оны тайлант хугацаанд нийт 6 газар хөндөх зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч, байгаль орчин болон цахилгаан, дулааны холболттой холбоотой шалгууруудыг хянаж зөвшөөрлүүдийг батлаад байна. Эдгээр газар хөндөх зөвшөөрөл авсан талбайнуудад газар шорооны ажил явагдаж байх үед GPS багаж болон бусад программын тусламжтай нарийвчилсан хэмжилт хийж, хөндөгдсөн газрын хэмжээг газарзүйн мэдээллийн санд тухай бүр бүртгэж байна.

Батлагдсан 6 газар хөндөх зөвшөөрлийн талбайд урьдчилан шимт хөрсний хуулах гүнийг талбай тус бүрийн хөрсний хэв шинж болон хийгдэх ажилтай уялдуулан MNS5916:2008. Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт стандартын дагуу 30-35см хуулж тухайн талбайд болон уурхайн шимт хөрсний овоолгод хадгалж байна.

Хүснэгт 3-13 Тайлант онд хөндөгдсөн талбайн мэдээлэл

| № | Байршил                | Огноо      | Шимт хөрсний бүртгэл |                     |                             | Газар хөндөх зөвшөөрлийн хуудас бөглөгдсөн эсэх | Тайлбар   |
|---|------------------------|------------|----------------------|---------------------|-----------------------------|---|---|
|   |                        |            | Талбай               | Эзлэхүүн            | Шимт хөрс хадгалах талбай   |   |   |
| 1 | Уурхайн карьер         | 2025.02.28 | 3.9 га               | 0 м <sup>3</sup>    | -                           | тийм  | Уулын ажил эхлүүлэх, хад чулуу гүү жалга бүхий гадарга      |
| 2 | Замын ажил             | 2025.03.06 | 3.3 га               | 6600 м <sup>3</sup> | Замын ажлын хажууд хадгалах | тийм  | Шимт хөрсийг 20-30 см-н зузаантай хуулсан.                  |
| 3 | Баяжуулах үйлдвэр “Мак | 2025.03.15 | 0.37 га              | 600 м <sup>3</sup>  | МАЗ шимт хөрсний            | тийм  | Шимт хөрсийг 20см зузаантай стандартын дагуу хуулж, хадгалж |

|   | аранжин зэс”           |            |         |                       | овоолийн талбай      |      | байна. Нуруулдан үүсгах овоолгын талбай |
|---|------------------------|------------|---------|-----------------------|----------------------|------|---|
| 4 | Уурхайн карьер         | 2025.04.04 | 29 га   | 43,500 м <sup>3</sup> | Шимт хөрсний овоолго | тийм | Шимт хөрсний овоолго хийх талбай        |
| 5 | Уурхайн карьер         | 2025.03.25 | 0.8 га  | 1600 м <sup>3</sup>   | Шимт хөрсний овоолго | тийм | Ил уурхайн ахилт                        |
| 6 | Хаягдлын далангийн зам | 2025.04.03 | 1.42 га | 2840 м <sup>3</sup>   | Шимт хөрсний овоолго | тийм | Хаягдлын далангийн зам                  |

#### 3.4.4 Гадаргын ус цуглуулах цөөрөм

Төслийн хүрээнд 2025 онд барилгын ажил болон тоосжилт дарахад усыг дахин ашиглах, гүний усны нөөцийг хэмнэх зорилгоор 2 талбайд ус хуримтлуулах цөөрмүүдийг ашигладаг бөгөөд Уурхайн төслийн талбайд хаягдлын сан 2, усан сан 2 байгаа бөгөөд эдгээрт зэрлэг ан амьтан орж үхэхээс сэргийлж 7 хоног 1-2 удаа тогтмол хяналт тавьж байна.



Зураг 3-43. Үерийн ус хуримтлуулах цөөрөм-1



Зураг 3-44. Үерийн ус хуримтлуулах цөөрөм – 2

#### 3.4.5 Амьтны үзэгдлийг бүртгэх, газар хөндөлт

Уурхайн үйл ажиллагааны болон ойр орчин дах амьтны үзэгдлийн бүртгэл хийх, ан амьтны талаарх мэдээллийг байгаль орчны мэргэжилтэнд мэдэгдэх талаар мэдээллийн самбарыг нүдэн харагдаж газар байршуулж үзэгдлийг бүртгэн зааварчилгааг өгөн ажиллаж байна. 2025 онд уурхайн хэмжээнд хулан, цагаан зээр, нөмрөгт тас, дэлдэн түлай, тарважи бүргэд, болжмор, дагуул галсүүл зэрэг 50 орчим амьтад бүртгэгдсэн байна.

| Тогтвортой хөгжил |                        |                     |                      |                              |
|-------------------|------------------------|---------------------|----------------------|------------------------------|
| Ан амьтан         |                        |                     |                      |                              |
| #                 | Үйлдвэр, Уурхай        | Огноо               | Ан амьтан            | Харгалсан төс, бүтцийн бүтэц |
| 1                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-09-06 17:25:08 | Балдуй амьсартуу мал | 2 Тооцрогдсон                |
| 2                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-09-06 17:30:56 | Хулэн                | 20 2н                        |
| 3                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-09-13 13:40:57 | Бор гүлэн            | 1 Тооцрогдсон                |
| 4                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-09-20 23:30:38 | Сүлж хуан            | 1 2н                         |
| 5                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-09-02 10:00:02 | Төрлөн бүргэд        | 3 Тооцрогдсон                |
| 6                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-09-02 10:02:07 | Ар сүүлт эвэр        | 4 Тооцрогдсон                |
| 7                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-02-27 10:00:49 | Хулэн                | 20 Тооцрогдсон               |
| 8                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-02-28 09:59:40 | Ар сүүлт эвэр        | 3 Тооцрогдсон                |
| 9                 | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-01-31 17:42:59 | Хулэн                | 5 Тооцрогдсон                |
| 10                | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-01-30 16:40:47 | Хулэн                | 14 Тооцрогдсон               |
| 11                | Эрдэнэс Цагаан Суварга | 2023-01-29 14:38:23 | Ар сүүлт эвэр        | 4 Тооцрогдсон                |

Зураг 3-45. Амьтны бүртгэлийн дотоод систем





Зураг 3-46. Уурхайн орчимд бүртгэгдсэн амьтад

### 3.4.6 Зэрлэг ан амьтдын тэмдэг, тэмдэглэгээ

Төслийн талбай болон нарангийн хоолой орчимд зэрлэг ан амьтан олноор идээшлэдэг тул дээр дурьдсан цэгүүдэд техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар анхааруулга сануулга өгч тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.



Зураг 3-47. Ан амьтдын тэмдэг

## БҮЛЭГ 4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Эрдэнэс Цагаан Суварга ХХК 2025 оны биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд зэрлэг амьтад зориулсан үст цэг гаргах, бүлгийн эхийг хамгаалах, Тооройн төглийг хашаалан хамгаалах арга хэмжээг зохион байгуулах гэсэн 3 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн гүйцэтгэлийн ажил үргэлжилж байна.

Хүснэгт 4-1 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлууд

| Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хүрээ | Тоо хэмжээ | Зардал                    | Хэрэгжилт   |
|--|---------------------------|------------|---------------------------|-------------|
| Тооройн төглийг хашаалах, хамгаалах зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгуулагаар хийлгүүлэх | Тооройн төгөл             | 1          | 20,000,000                | Хийгдсэн    |
| Тооройн төглийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хашаалан хамгаалах              | Тооройн төгөл             | 1          | Хөрөнгө оруулалтын зардал | Хийгдсэн    |
| Зэрлэг амьтад зориулсан үст цэгийг шинээр байгуулах                                      | Ганзага үүл               | 1          | 10,000,000                | Хийгдэж буй |
| <i>Нийт зардал, төг</i>  |                           |            | 35,000,000                |             |

### 4.2.1 Тооройн төглийг хашаалах, зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх

2024, 2025 онууд байгаль орчин, биологийн олон янз байдлын хамгаалах ажлын хүрээнд Нарангийн бүлгийн Экосистемийг хамгаалах, судлах арга хэмжээг авав. Нарангийн бүлгийг хамгаалах зорилгоор нарангийн хашаалах зөвлөх үйлчилгээ болон амьтны судалгааг мэргэжлийн байгууллага болох "Уур амьсгалын өөрчлөлт ба хүрээлэн байгаа орчин" ТББ -аар хийлгэсэн бол Тооройн төглийг хамгаалах төлөвлөгөөг дотоодоо гарган төлөвлөгөөний дагуу хашаалан хамгаалав.



Зураг 4-1. Судалгааны ажлын тайлан

#### 4.2.2 Тооройн төглийг хашаалан хамгаалах

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Тооройн төгөл бүхий 400 метр урт, 8500 м/квадрат талбайн хашааг барьж тохижуулж дууссан. Нийт 31 ш нас бие гүйцсэн, 10 ш зулзаган тоорой модтой талбай хамрагдсан. Цаашид мэргэжлийн байгууллагаар Тоорой модны насжилт, ургах орчин, үржүүлэх боломжийг судлуулхаар төлөвлөн ажиллаж байна.

Хүснэгт 4-2. Тоорой мод хамгаалахад хийгдэх ажлын жагсаалт

| № | Хийгдэх ажлууд             | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Хугацаа     | Тайлбар                                |
|---|----------------------------|-------------|------------|-------------|--|
| 1 | Тоорой мод хамгаалах хашаа | м           | 434        | 10/05-10/11 | Тоорой мод хамгаалах төмөр хашаа барих |
| 2 | Танилцуулга самбар         | ш           | 1          | 10/20       | Иргэдэд мэдээлэл олгох                 |

Хүснэгт 4-3. Материалын зардал

| №           | Хийгдэх ажлууд                  | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ, төг     |
|-------------|---------------------------------|-------------|------------|----------|-------------------|
| 1           | Хамгаалах төмөр хашаа           | м           | 700        | 37 500   | 26 250 000        |
| 2           | Нүх ухагч багажийн бензин       | л           | 30         | 2 780    | 83 400            |
| 3           | Хашааг барих гагнуурын хэрэгсэл | ком         | 1          | -        | -                 |
| 4           | Танилцуулга самбар              | 2 ш         | ш          | 500 000  | 1 000 000         |
| <b>Нийт</b> |                                 |             |            |          | <b>27 333 400</b> |

Хүснэгт 4-4. Ажиллах хүч

| №           | Ажилчид                   | Хүний тоо | Ажилласан хоног | Томилолт, цалин /хоногт/ | Нийт үнэ, төг     |
|-------------|---------------------------|-----------|-----------------|--------------------------|-------------------|
| 1           | Байгаль орчны мэргэжилтэн | 2         | 10              | 400 000                  | 1 000 000         |
| 2           | Туслах ажилтан            | 2         | 10              | 300 000                  |                   |
| 3           | Гагнуурчин                | 1         | 10              | 150 000                  |                   |
| 4           | Үйлчилгээний жолооч       | 1         | 10              | 150 000                  |                   |
| <b>Нийт</b> |                           |           |                 |                          | <b>10 000 000</b> |

Хүснэгт 4-5. Ажиллах техник

| №           | Техникийн нэр | Зарцуулах түлш /л/         | Ажилласан цаг | Нийт түлш /л/ | Нэгж үнэ /₮/     | Нийт үнэ /₮/   |
|-------------|---------------|----------------------------|---------------|---------------|------------------|----------------|
| 1.          | Ачааны машин  | -                          | 20            | -             | -                | -              |
| 2.          | LC-79         | 100 км-т 14 л /200км,өдөр/ | 10 хоног      | 28л*10 хоног  | 280л*3250 төгрөг | 910 000        |
| <b>Нийт</b> |               |                            |               |               |                  | <b>910 000</b> |

Хүснэгт 4-6. Зарцуулах нийт төсвө

| №                  | Хийгдэх ажил      | Төсөв, төг        |
|--------------------|-------------------|-------------------|
| 1                  | Материалын зардал | 27 333 400        |
| 2                  | Ажиллах хүч хүч   | 10 000 000        |
| 3                  | Ажиллах техник    | 910 000           |
| <b>Нийт зардал</b> |                   | <b>38 243 400</b> |



Зураг 4-2. Тооройн төгслийг хашаала ажлын явц

#### 4.2.3 Зэрлэг ан амьтдад зориулсан үст цэг байгуулах

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд зэрлэг амьтдад зориулсан үст цэг гаргах ажлыг гүйцэтгэж байна. Дорноговь аймгийн аялал жуулчлалын газар болон Мандах сумын засаг дарга нараас үст цэг гарах тохиромжтой газруудын мэдээллийг авсан. Хүдгийн өрөмдлөгийн ажлыг “Ганзага уул”-нд Хишиг Юниверс ХХК-р гүйцэтгүүлж тоноглолыг хийсэн. Хүдгийн байр болон нарны цахилгаан систем тоноглох ажил 11-р сарын 1-с өмнө хийж дуусгахаар ажиллаж байна.



Зураг 4-3. Ганзага ууланд гаргасан үст цэгийн өрөмдлөгийн ажил

## БҮЛЭГ 5 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд түлхүү барилга угсралтын ажил хийгдэж хүдэр олборлолтын эхний жил байх тул техникийн нөхөн сэргээлтийн хүрээнд шимт хөрс хуулах, тээвэрлэх, хадгалах ажлуудыг төлөвлөж, биологийн нөхөн сэргээлтийн хүрээнд уурхайн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртөж болзошгүй модыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан.

Төслийн талбайд 1000 гаруй мод, ногоон байгууламжийг арчилж тордон үргүүлж байгаа бөгөөд модний төрлөөр авч үзвэл хайлаас 47%, жигд 26%, сүхай 28%, үд 1% хувийг тус тус эзэлж байна. Хотхоны амрах барилга байгууламжийн явган хүний замыг дагуулан тарьж үргүүлсэн бөгөөд ургамалыг тогтмол услаж, тордож ногоон байгууламаар дамжуулан агаарын чанар, орчны тоосжилтийг бууруулахыг зорьж байна. Мод ногоон байгууламжийн усалгааг тогтмол хийдэг.



Зураг 5-1. Ногоон байгууламжийн арчилгаа, тордолгоо

Хүснэгт 5-1 Нөхөн сэргээлийн төлөвлөгөөний хэрэгжилт

| № | Нөхөн сэргээлийн зорилт  | Нөхөн сэргээлийн арга хэмжээ  | Хэмжих нэгж        | Тоо хэмжээ | Зардал                 | Хэрэгжилт  |
|---|--------------------------|---|--------------------|------------|------------------------|--|
| 1 | Техникийн нөхөн сэргээлт | Шимт хөрс хуулах  | Га                 | 38,79      | Үйл ажиллагааны зардал | Тайлант онд нийт 38.79 га газарт шимт хөрсний хуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.  |
| 2 |                          | Шимт хөрсийг овоолгод тээвэрлэх   | Мян.м <sup>3</sup> | 55,14      |                        | Шимт хөрсийг өөрөө бүүлгагч техник ашиглан овоолгийн талбай луу тээвэрлэсэн.   |
| 3 |                          | Шимт хөрсний овоолгыг хэлбэржүүлэх, хэвгийжүүлэх  | Мян.м <sup>3</sup> |            |                        | Шимт хөрсний овоолгийг хэлбэржүүлэн үс, салхины хүчин зүйлээс хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.                         |
| 4 |                          | Үржил шимт хөрсний овоолгыг хамгаалах, хадгалах   | га                 |            |                        | Шимт хөрсийг тусгай бэлтгэсэн талбайд бүүлгаж тэмдэгжүүлсэн.   |
| 5 | Биологийн нөхөн сэргээлт | Хаягдлын далангийн барилга байгууламжинд өртөж буй хайлаас модыг шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулах | ш                  | 25         |                        | Хаягдлын далангийн барилга байгууламжийн ажилд өртөж буй хайлаас моднуудыг судалж бүртгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан. |

## 5.1 ШИМТ ХӨРСНИЙ ХУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ

2025 онд нийт 38.79 га газарт шимт хөрсний хуулалтын ажил, 55.14 мян.м3 шимт хөрс овоолго луу тээвэрлэж хэлбэржүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.



Зураг 5-2. Шимт хөрсний хадгалалт

## 5.2 ХАЯГДЛЫН ДАЛАНГИЙН АЖИЛД ӨРТӨЖ БУЙ ХАЙЛААС МОДДЫГ ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛ

Цагаан суварга төслийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын далангийн барилгын ажилд шүүд байдлаар устгах эрсдэлтэй Өнгөтийн сайр дагуух 25 ш хайлаас модыг шилжүүлэн суулгах төлөвлөлтийг боловсруулсан. Далангийн ажилд шүүд өртөх 27 ш нас бие гүйцсэн хайлаас модыг талбайгаас 1 км-н зайд орших хөрс, ургамалжилтын хувьд ойролцоо талбайд шилжүүлэн суулгаж байна. Мөн Дорноговь аймгийн Байгаль орчны газраар Ойн экологийн эдийн засгийн үнэлгээ тогтоолгож хохирлыг барагдуулсан.



Зураг 5-3. Шилжүүлэн суулгалт даах модуудыг ангилж буй байдал



Зураг 5-4. Хайлаас моддыг шилжүүлэн суулгаж буй явц

### 5.3 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол орон даяар Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн үүр амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж байгаа билээ. Энэхүү хөдөлгөөний хүрээнд Эрдэнэс Цагаан Суварга ХХК нь 2025 онд 1.5 га талбайд 500 ширхэг мод тарихаар төлөвлөснөөс 650 ш мод тарьж ажиллав.

Хүснэгт 5-2 Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэрэгжилт

| № | Нөхөн сэргээлтийн зорилт                          | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ           | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Зардал                 | Хэрэгжилт  |
|---|---|---|-------------|------------|------------------------|--|
| 1 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих | Тариалах суулгац авах                   | ш           | 500        | 5,000,000              | Хайлаас 250 ш сухай 250 ш суулгац худалдан авч бэлтгэсэн.          |
| 2 |   | Тариалах талбайг бэлтгэх                | га          | 1,5        | 100,000                | Хаврын мод тарилтад  |
| 3 |   | Тарилт хийх                             | ш           | 500        | 1,600,000              |  |
| 4 |   | Модны усалгаа, арчилгаа, тордлогоо хийх | удаа        | Тухай бүрд | Үйл ажиллагааны зардал | Мандах сумын төвд орон нутгийн иргэдтэй хамтран 300 ш мод тарьсан. |

| №                       | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Зардал           | Хэрэгжилт   |
|-------------------------|--------------------------|-------------------------------|-------------|------------|------------------|---|
|                         |                          |                               |             |            |                  | Намрын мод тарилтад зориулан ажилчдын хотхон 350 ш хайлаас модыг суулгаж ажилласан. |
| <b>Нийт зардал, төг</b> |                          |                               |             |            | <b>7,700,000</b> |   |


## БҮЛЭГ 6 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн 2023 онд батлагдсан БОННУ-ний нэмэлт тодотголын тайлангийн Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2024 онд нөхөн төлбөрийн хэмжээг нөлөөллийн бүсийн айлууд болон компанийн удирдлагуудад танилцуулж нөхөн олговрын хэмжээг тогтоосон.


2025 онд эдгээр айлуудтай гэрээ байгуулах, нөхөн олговрыг олгох, газрын асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөсний дагуу “Шар хайрхан уул”, “Хөтөл үс” “Хөөврийн улаан”, Түмэн өлзий уул нэртэй газарт орших 4414002711, 4414002692, 100700792, 4414003270, дугаартай гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий тус бүр 1.2 га талбайт өвөлжөө, хаваржааг 2025 оны 1 сарын 10-д 006-5125, 007-5125, 008-5125 тоот гэрээг байгуулж нүүлгэн шилжүүлснээр Мандах сумын засаг дарга газар эзэмших эрхийг дуусгавар болгосон захиарамжийг гаргасан.

Хүснэгт 6-1 Нөхөн олговор олгосон өрхийн ерөнхий мэдээлэл


| №                | Нөлөөллийн бүсийн иргэд | Нэгж талбарын дугаар | Хүчинтэй хугацаа |
|------------------|-------------------------|----------------------|------------------|
| 1                | О. Эрдэнэбаатар         | 4414002711           | 2026             |
| 2                | Ч. Бямба-Эрдэнэ         | 4414003270           | 2026             |
| 3                | Е. Чинтогтох            | 4414002692           | 2026             |
| 4                | А. Долдбаяр             | 100700792            | 2026             |
| Нийт зардал, төг |                         | 220,000,000          |                  |



Зураг 6-1. Цагаан суваргын төслийн нөлөөллийн бүсийн айлууд



Зураг 6-2. Ё. Чинтогтох, Ч. Бямба-Эрдэнэ, А. Долдбаяр нарын газар эзэмших эрхийг дуусгавар болгосон захирамж



Зураг 6-3. О. Эрдэнэбаатарын газар эзэмших эрхийг дуусгавар болгосон захирамж.



*Зураг 6-4. Нөлөөллийн бүсийн өрх Ч. Бямба-Эрдэнэд хүлээлгэн өгсөн биет нөхөн олговрын зөврийн сууц болон тэмээний хашаа*



*Зураг 6-5. Нөлөөллийн бүсийн өрхөд хүлээлгэн өгч буй нь*

## БҮЛЭГ 7 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эрдэнэс цагаан суварга” ХХК-ийн Цагаан суваргын зэс-молибдены ордын талбайд 2010 онд ШУА ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги археологи авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Талбайн хэмжээнд хийсэн археологи-үгсаатны судалгааны явцад янз бүрийн түүхэн үед холбогдох нийт 27 бүлш, чулуун байгууламж, дурсгал илрүүлсэн бөгөөд 2011 онд авран хамгаалах ажил хийгдэж, одоогийн байдлаар төслийн талбайд түүх, соёлын өв байхгүй байна. Гэвч төслийн үйл ажиллагааны явцад соёлын өв олдохыг үгүйсгэхгүй. Иймд уул уурхайн үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв уурхайн үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах арга хэмжээг авна. Нийт ажилчидад санамсаргүй олдворын үед авах арга хэмжээний тухай сургалт орж зааварчилгаа өгч ажилласан.

## БҮЛЭГ 8 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Цагаан суваргын зэс молибдены ордыг ашиглах төслийн 2025 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд 8 болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөллийг бууруулах 6 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлсэн.

Хүснэгт 8-1 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх арга хэмжээ  | Арга хэмжээний цар хүрээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг    | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Хэрэгжилт   |
|---|--------------------------------------|--|--------------------------|------------|------------------------|------------------|--------------------------------|---|
| 1 | Гал түймэр                           | Гал түймэртэй тэмцэх бүтэц орон тоог батлуулж ажиллуулах, Техник, тоног төхөөрөмжийг бүрдүүлэх   | Төслийн талбай           | 4-6 хүн    | Үйл ажиллагааны зардал |                  | Жилийн турш                    | 2025 онд бүтэц, орон тоогоор Онцгой байдлын мэргэжилтэн-2, гал унтраах автомашины жолооч-2 тус тус байхаар төлөвлөсөн бөгөөд Онцгой байдлын мэргэжилтэн-1 нэмж авах сонгон шалгаруулалт хийгдсэн. (Дэлгэрэнгүйг 8.1-с үзнэ үү.)   |
| 2 |                                      | Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх      | Төслийн талбай           | 10-20      | Үйл ажиллагааны зардал |                  | I улирал                       | Оффис, эмнэлэг, хоол үйлдвэрлэлийн газар, амрах байр, тоглоомын байр, хувцас угаалгын газар, ЗҮТ, Баяжуулах үйлдвэрийн баригдаж буй хэсгүүдэд гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг норм стандартын дагуу байрлуулж, хяналтын картанд сар бүр тэмдэглэгээ хийж ажиллаж байна. MNS 5566:2020(Дэлгэрэнгүйг 8.2-с үзнэ үү.) |
| 3 |                                      | Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц, барилгын зохион байгуулалт зэргийг эзэмшлийн объект бүрд онцлогийг тусган шинэчлэн тавих | Төслийн талбай           | 5          | Үйл ажиллагааны зардал |                  | I улирал                       | Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц барилгын зохион байгуулалт зэргийг эзэмшлийн объект бүрд шинэчлэн байрлуулсан. (Дэлгэрэнгүйг 8.3-с үзнэ үү.)   |

| №                     | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл                        | Урьдчилан сэргийлэх арга хэмжээ   | Арга хэмжээний цар хүрээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг       | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Хэрэгжилт  |
|-----------------------|---|---|--------------------------|------------|---------------------------|------------------|--------------------------------|--|
| 4                     | Үер усны аюул   | Далан, шуудуу татах, техникийн бэлэн байдлыг хангах                                     | Төслийн талбай           | 12         | Хөрөнгө оруулалтын зардал |                  | Жилийн түрш                    | Төслийн талбайд үер усны гамшгаас хамгаалах далан, үер шуудууг татах техникийн бэлэн байдлыг хангаж мэргэжлийн ангийг томилсон. (Дэлгэрэнгүйг 8.3.1-с үзнэ үү.)              |
| 5                     | Цахилгаан тоног төхөөрөмж болон цахилгаан гүйдэлд нэрвэгдэх | Анхан шатны тусламж үйлчилгээний сургалт зохион байгуулах                               | Төслийн талбай           | 4          | Үйл ажиллагааны зардал    |                  | Жилийн түрш                    | Ажлын байранд тохиолдох анхан шатны тусламж үйлчилгээний сургалтыг тогтмол зохион байгуулсан. (Дэлгэрэнгүйг 8.3.2-с үзнэ үү.)  |
| 6                     | Гал гарах аянга бүүх  | Газардуулгын хэмжилт хийлгэх  | Төслийн талбай           | 8          | 1,000,000                 | 8,000,000        | Жилийн түрш                    | Газардуулгын хэмжилт хийх ажлыг “Шүгэм” ХХК-р гүйцэтгүүлж байна. (Дэлгэрэнгүйг 8.5-с үзнэ үү.)   |
| 7                     | Аюулгүй ажиллагааны зааварчилгаа ноцтой зөрчигдөх           | Аюулгүй ажиллагааны зааварчилгааг нийт ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавих | Төслийн талбай           | 74         | Үйл ажиллагааны зардал    |                  | Жилийн түрш                    | Аюулгүй ажиллагааны зааварчилгааг улирал бүр зохион байгуулж ажилладаг. Өдөр тутмын ажлын байрны үзлэгийг тогтмол зохион байгуулж ажилласан. (Дэлгэрэнгүйг 8.3.3-с үзнэ үү.) |
| 8                     | Байгалийн давагдашгүй хүчин зүйл                            | Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах  | Төслийн талбай           | 8          | Үйл ажиллагааны зардал    |                  | Жилийн түрш                    | 2025 оны “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулан Дорноговь аймгийн онцгой байдлын газраар хянуулан баталсан. (Дэлгэрэнгүйг 8.3.4-с үзнэ үү.)                          |
| <b>Нийт зардал, т</b> |   |   |                          |            |                           |                  |                                | <b>8,000,000</b>   |

## 8.2 БҮТЭЦ ОРОН ТООГ БАТЛУУЛАХ

2025 онд бүтэц, орон тоогоор Онцгой байдлын мэргэжилтэн-2, гал унтраах автомашины жолооч-2 тус тус байхаар төлөвлөсөн бөгөөд Онцгой байдлын мэргэжилтэн-1 нэмж авах сонгон шалгаруулалт хийгдсэн.


## 8.3 ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Оффис, эмнэлэг, хоол үйлдвэрлэлийн газар, амрах байр, тоглоомын байр, хувцас угаалгын газар, ЗҮТ, Баяжуулах үйлдвэрийн баригдаж буй хэсгүүдэд гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг норм стандартын дагуу байрлуулж, хяналтын картанд сар бүр тэмдэглэгээ хийж ажиллаж байна.

Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц барилгын зохион байгуулалт зэргийг эзэмшлийн объект бүрд шинэчлэн байрлуулсан



Зураг 8-1. Галын Аюулгүй байдлын тоноглол



Зураг 8-2. Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц, барилгын зохион байгуулалт

### 8.3.1 Галын аюулаас хамгаалах үер, шуудуу

Төслийн талбайд үер усны гамшгаас хамгаалах далан, үер шуудууг татах техникийн бэлэн байдлыг хангаж мэргэжлийн ангийг томилсон.

### 8.3.2 Анхан шатны тусламж үйлчилгээний сургалт зохион байгуулалт

Ажлын байранд тохиолдох анхан шатны тусламж үйлчилгээний сургалтыг тогтмол зохион байгуулсан.

### 8.3.3 Газардуулгын хэмжилт хийлгэх

Газардуулгын хэмжилт хийх ажлыг “Шугам” ХХК-р гүйцэтгүүлж байна.

### 8.3.4 Аюулгүй ажиллагааны хяналт, шалгалт

Аюулгүй ажиллагааны зааварчилгааг улирал бүр зохион байгуулж ажилладаг. Өдөр тутмын ажлын байрны үзлэгийг тогтмол зохион байгуулж ажилласан.



Зураг 8-3. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг нийт ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт

## 8.4 ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулан Дорноговь аймгийн онцгой байдлын газраар хянуулан баталсан.



Зураг 8-4. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

## БҮЛЭГ 9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Эрдэнэс Цагаан Суварга ХХК нь “Монголын Алт” ХХК-ийн ерөнхийлөгчийн 2021 оны 06-р сарын 23-ны өдрийн А/383 тоот тушаалаар батлагдсан “Хог хаягдлын менежментийн журам”-ыг үүрхэйн үйл ажиллагааны бүхий л үе шатанд мөрдөн ажилладаг. Тус журмыг зорилт нь:

- Хог хаягдлын тухай хууль, журам, сатндартыг дагаж мөрдөх
- Хог хаягдлын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэхэд оролцох ажиллагсад, албан тушаалтны оролцоо, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох
- Хог хаягдлын менежментийн үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж байгаа эсэхийг хянах, үнэлгээ хийх, сайжруулалт хийх
- Хог хаягдлын статистик тоон баримт, хяналт мониторингийн үр дүнг эмх цэгцтэй нэгтгэн хадгалах, үрт хугацааны мэдээллийн санг үүсгэх, шаардлагатай газруудад танилцуулах, мэдээлэх
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах боломж бололцоог нэмэгдүүлэх.

Журмын дагуу хог хаягдлыг үндсэн хоёр төрөлд буюу энгийн болон аюултай хог хаягдал гэж ангилдаг. Энгийн хог хаягдлыг дахин ашиглах боломжтой хог хаягдал болон дахин ашиглах боломжгүй хог хаягдал гэсэн 2 үндсэн төрлөөр ангилж байна. Харин аюултай хог хаягдлыг дахин ашиглах боломжтой аюултай хог хаягдал, дахин боловсруулах боломжтой аюултай хог хаягдал, дахин боловсруулах боломжгүй аюултай хог хаягдал болон тусгай буюу эмнэлгийн хог хаягдал гэсэн 4 үндсэн төрлөөр ангилж байна.



Зураг 9-1. Хог хаягдлын менежментийн журмын хог хаягдлын ангилан ялгалт

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, бууруулах арга хэмжээ  | Хэрэгжилт  |
|---|----------------------|--|--|
| 1 | Ахуйн хог хаягдал    | Ахуйн хатүү хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн савыг төслийн талбайд байршуулах | Уурхайн талбайн хэмжээнд энгийн хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд буюу ажилчдын кемп, оффис, гал тогоо гэх мэт 6 газарт ангилан ялгалттай хогийн савыг стандарт шаардлагын дагуу байрлуулаад байна. (Дэлгэрэнгүйг 9.1.1-с үзнэ үү.)   |
| 2 |                      | Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлэх  | Цагаан суваргын ордыг ашиглах төслийн үйл ажиллагаа 2023 оноос ахин эхэлж буй тул төслийн талбайд явагдаж байгаа үйл ажиллагааны дийлэнх хувийг барилга байгууламжийн бүтээн байгуулалтын хувийг эзлэж байна. Тиймээс бид барилгын материалын хог хаягдлыг ахин ашиглах арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүл байна. Тайлант онд хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд барилгын материалаас гарах хог хаягдлыг ахин бага хэмжээтэй түр сүүц, гадаад талбайн тохижилт, засвар үйлчилгээ зэрэг ажлуудыг хийхэд ашиглаж байна. (Дэлгэрэнгүйг 9.1.2-с үзнэ үү.)   |
| 3 |                      | Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах цэгийн зураг төслийг гаргаж, төлөвлөх, ангилан ялгалттай цэгийг байгуулах                 | Төслийн үйл ажиллаганы түр хэрэгүүлэх хог хаягдлын менежментийг боловсруулахаар зорьж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд тайланд онд төслийн үйл ажиллагаанаас үүсч байгаа хог хаягдлын судалгааг дотооддоо хийж урьдчилсан төлөвлөлтийг гаргасан. Тус төлөвлөгөөнд хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах цэгийн урьдчилсан зураг төслийг боловсруулсан. (Дэлгэрэнгүйг 9.1.3-с үзнэ үү.)   |
| 4 |                      | Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах төсөл, хөтөлбөрт эсвэл гэрээт компанид нийлүүлэх     | Компанийн хог хаягдлын менежментийн зарчмын дагуу "Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг нийлүүлэх гэрээг Төвшин сайхан" -тэй "Ахуйн хуурай хог хаягдлыг нийлүүлэх" Мандах сумын засаг даргатай, "Хаягдал тос, масло нийлүүлж устгуулах" гэрээг "ОБ - Ойл ХХК", "Саус ресурс ХХК", "Монфити - Ойл ХХК", "Аюултай хог хаягдал шилжүүлэх" гэрээг Цэцүүх трейд ХХК компаниудтай байгуулан ажиллаж байна. Эдгээр гэрээнүүд тухайн хог хаягдлыг нийлүүлэхдээ тодорхой хэмжээ заасан байдаг бөгөөд төслийн үйл ажиллагаа эхлээд удаагүй тул тайлант онд хараахан хог хаягдлуудын нөөцийг нийлүүлэгүй байна. нөөцийг түр талбайд хадгалж байна. (Дэлгэрэнгүйг 9.1.3-с үзнэ үү.) |
| 5 |                      | Хүнсний үлдэгдлээр бордоо хийж түрших  | Бид хоол үйлдвэрлэлийн газраас үүссэн ногооны хальс, өндөгний хальс, кофены шаар зэрэг хүнсний хаягдлыг цуглуулан хуурай навч, хөрстэй   |

|    |                     |   |  |
|----|---------------------|---|--|
|    |                     |   | давхарлан байрлуулж, үс шүршин чийгшүүлсэн. Үүнийг тагтай саванд 6 долоо хоног хадгалж, долоо хоног бүр хутган агааржуулж, үс шүршин чийгшүүлэн тагтай саванд 6 долоо хоногийн турш хадгалж, долоо хоног бүр хутган агаар оруулж исэлдүүлэх аргаар туршиж үзэв. (Дэлгэрэнгүйг 9.1.5-с үзнэ үү.)  |
| 6  |                     | Бусад хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр устгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх   | "ЭЦС" ХХК нь Хог хаягдлын хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайн төлөвлөгөөний хүрээнд Дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхгүйгээр хог хаягдлыг устгах, стандарт шаардлага хангасан зуухыг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд одоогоор судалгааны ажил нь дуусч худалдан авалтын ажил нь явагдаж байна. (Дэлгэрэнгүйг 9.1.6 үзнэ үү.) |
| 7  |                     | Төслийн талбай орчмын эргэн тойронд цэвэрлэгээ хийх   | Төслийн талбайн ойр орчимд долоо хоног бүрийн ням гаригт бүх хэсэг нэгжийг хамруулан их цэвэрлэгээ тогтмол хийж байна. (Дэлгэрэнгүйг 9.1.7 үзнэ үү.)   |
| 8  | Аюултай хог хаягдал | Засвар үйлчилгээний төвөөс үүсэх аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, түр хадгалах цэгийн зураг төсөл, төлөвлөлтийг гаргаж, байгуулах                        | ЭЦС ХХК нь дотоод хэрэгцээнд зориулсан агуулах шатахуун түгээх станц барихаар төлөвлөсөн бөгөөд энэхүү төлөвлөгөөнд төслийн засвар үйлчилгээний төвөөс үүсэх хаягдал тосыг хадгалах 25м <sup>3</sup> хэмжээ бүхий 2 агуулахын төлөвлөсөн. Тус тосны агуулахын барилгын ажил нь дууссан бөгөөд 2025 оны нэгдүгээр улиралд ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна. (Дэлгэрэнгүйг 9.1.8-с үзнэ үү.)                          |
| 9  |                     | Засвар үйлчилгээний төвөөс үүсэх аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай хийсэн гэрээний дагуу төслийн талбайгаас тээвэрлүүлж, устгуулах | Төслийн хэмжээнд үүсэх хаягдал тос нийлүүлэх гэрээг "ОБ - Ойл ХХК", "Саус ресурс ХХК", "Монфити - Ойл ХХК байгуулсан бөгөөд тайлан оны 10-р сарын 25 онд төслийн талбайн хаягдал тос түр хадгалах цэгт хүримтлагдсан байсан 10тн тос маслыг аюултай хог хаягдлын дагуулах хуудсын дагуу акт үйлдэн гэрээт байгууллагад өгсөн. (Дэлгэрэнгүйг 9.1.9-с үзнэ үү.)  |
| 10 |                     | Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг байршуулж, төслийн талбай дээр түр хадгалан эрх бүхий байгууллагад шилжүүлэх                      | Тайлант онд төслийн анхан тусламжийн төвөөс 12кг эмнэлгийн халдвартай хог хаягдал, 1.5кг эмнэлгийн хурц үзүүртэй иртэй хог хаягдал, 2 ширхэг аюултай хайруаг үүссэнийг тусгай зөвшөөрөлтэй байгууллагад шилжүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг 9.9.10-с үзнэ үү.)   |
| 11 |                     | Дулааны станцаас урьдчилсан тооцоогоор жилд 3086.7тн нунтаг болон бүхэл үнс ялгарах бөгөөд хаягдал үнсний шинжилгээг итгэмждэгдсэн лабораториор шинжлүүлэн, | Тайлант онд Дулааны станц ашиглалтанд ороогүй  |

|                         |  |   |                   |
|-------------------------|--|---|-------------------|
|                         |  | үр дүн дээр үндэслэн БНБД 41-03-13-ын 4.10 дугаар заалтын дагуу ил үүрхайд ашиглах.   |                   |
| 12                      |  | Хог хаягдлын тоо бүртгэлийг батлагдсан маягт болон "Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт"-ын дагуу тухай бүр хөтөлж, сар бүрийн эцэст дотоод системд бүртгэх, тоо хэмжээг хянах |                   |
| 13                      |  | Компанийн нийт ажилчдад хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлын хэмжээг бүүрүүлэх тухай сургалт орох   |                   |
| <b>Нийт зардал, төг</b> |  |   | <b>18,400,000</b> |

## 9.1 АХУЙН ХОГ ХАЯГДАЛ

“ЭЦС” ХХК нь төсөл, үйл ажиллагаандаа олон улсын Байгаль орчны, Нийгмийн болон Захиргааны (БОНЗ) стандартыг нэвтрүүлж эхлээд байгаа бөгөөд БОНЗ-ын шаардлагад нийцүүлэн ахуйн хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, сэргээн ашиглах, ангилан ялгах болон аюулгүй устгах, шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Тайлант онд төслийн үйл ажилгаанаас гаргах дахин боловсруулах боломжтой хог хаягдалд ангилал тогтоож мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна.

### 9.1.1 Хог хаягдлын ангилалт, ялгалт

Уурхайн талбайд үүсэж буй нийт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг хэрэгжүүлэх нь хог хаягдлын дахин ашиглалт, дахин боловсруулалтыг хэрэгжүүлэх гол үндэс юм. Иймд төслийн талбайн хэмжээнд энгийн хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд буюу ажилчдын кемп, оффис, гал тогоо зэрэг газруудад ангилан ялгалттай хогийн савыг стандарт шаардлагын дагуу байрлуулаад байна.


Тайлант онд үйл ажиллагаанаас үүсэж буй энгийн хог хаягдлыг дараах 2 төрлөөр ангилан ялгаж байна. Үүнд:

- Дахин ашиглах боломжтой хог хаягдал (Хуванцар, мод, төмөр)
- Дахин ашиглах боломжгүй бусад хог хаягдал



Зураг 9-2. Төслийн талбайд байрлуулсан ангилан ялгалттай хогийн савнууд

Уурхайн хог хаягдлын менежментийн хүрээнд стандарт шаардлагад нийцүүлсэн ангилан ялгалттай хогийн савны тэмдэг:



Зураг 9-3. Ангилан ялгалттай хогийн савны тэмдэг, тэмдэглэгээ

### 9.1.2 Хог хаягдал дахин ашиглалт

Тус компаний Цагаан суваргын ордыг ашиглах төслийн үйл ажиллагаа 2023 оноос ахин эхлүүлж буй тул төслийн талбайд явагдаж байгаа үйл ажиллагааны дийлэнх хувийг барилга байгууламжийн бүтээн байгуулалтын хувийг эзлэж байна. Тиймээс бид барилгын материалын хог хаягдлыг ахин ашиглах арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлж байна. Тайлант онд хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд барилгын материалаас гарах хог хаягдлыг ахин бага хэмжээтэй түр сууц, гадаад талбайн тохижилт, засвар үйлчилгээ зэрэг ажлуудыг хийхэд ашиглаж байна.

#### Усны нөөцийн агуулах

Төслийн гал тогооны ундны усны нөөцийн 100тн агуулахыг үлдэгдэл барилгын материалыг ашиглан гадна болон дотор хэсгийг засварлан ашигласан.



*Зураг 9-4. Гал тогооны ундны усны 100тн нөөцийн агуулах*

### **Тос тунгаагуур болон тосны шүүр хадгалах сав**

Засвар үйлчилгээний төвөөс үүсэж буй хаягдал тос болон тосны үүрийг түр хадгалах цэгт түр хадгалан тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлж өгдөг бөгөөд тосны шүүрний тосыг тунгаах тунгаагуур, болон тосны шүүр хадгалах савыг хаягдал материал хийж ашиглав.



*Зураг 9-5. Тосны шүүрнээс хаягдал тос ялгах тунгаагуур*



Зураг 9-6. Тосны шүүрний хаягдал цуглуулах сав

### Эрүүл мэндийн хог хаягдлын цэг

Уурхайн анхан тусламжийн төвөөс үүсэж буй эмнэлгийн аюултай хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/505-р тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”-ын дагуу төслийн талбайд түр хадгалан, Дорноговь аймгийн Мандах сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан “Эмнэлгийн тусгай хог хаягдлыг устгах гэрээ”-ний дагуу сумын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлдэг бөгөөд түүнчлэн түр хадгалах савыг хаягдал материалаар хийж ашиглав.



Зураг 9-7. Эрүүл мэндийн хог хаягдал түр хадгалах цэг

### **Харуул хамгаалалтын байр**


Төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайд харуул хамгаалалтын 4 пост байх бөгөөд өвөл зун ашиглах боломжтой 3 харуулын байрыг барилгын хаягдал материалыг ашиглан шийдэв.



*Зураг 9-8. Харуул хамгаалалтын байр*

### **Агуулахын дээвэрлэлт**

Хаягдал барилгын материалыг боломжит бүх засвар үйлчилгээнд ашигладаг бөгөөд контейнерийн агуулахын дээврийг засварласан.



*Зураг 9-9. Агуулахын дээвэрлэлт*

### **Тамхины цэг**

Байгууллагын дотоод журам болон ХАБЭА-н ажлын хүрээнд нийтийн талбайд тамхи татахыг хязгаарладаг бөгөөд тодорхой цэгүүдэд тамхины цэгүүдийг байршуулан хяналт тавин

ашигладаг, Энэхүү ажлын хэрэгжилтэнд тамхины цэгийн бүхээгийг мөн хаягдал барилгын материал ашиглан хийв.



Зураг 9-10. Тамхины цэг

#### Гадаад талбайн тохижилтын сандал

Хаягдал барилгын материалыг ашиглан А,В,С,Д,Е амрах байрнуудны үүдний тохижилтонд сандлуудыг хийж байршуулав.



Зураг 9-11. Гадна талбайн тохижилтын сандал засварлалт

### Бусад

Хаягдал поошик, шилэн сав зэргийг ашиглан хогийн сав, зай хураагуур цуглуулах сав, тамхины ишний сав зэргийг хийн ашиглав.



Зураг 9-12. Хогийн сав болон зай хураагуур цуглуулах сав

### 9.1.3 Хог хаягдал түр хадгалах цэгийн дахин төлөвлөлт


Төслийн үйл ажиллагааны явц ашиглагдах хог хаягдлын менежментийг боловсруулж төлөвлөлт, сайжруулалт хийн ажиллахыг зориж байна. Үүний хүрээнд тайланд онд төслийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна.

Тус төлөвлөгөөний дагуу дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах цэгийн урьдчилсан зураг төслийг боловсруулсан. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан хог хаягдлын түр ангилан ялгах цэг нь 30м х 15м талбайтай, 4м өндөр агуулах хэлбэрийн загвартай байх бөгөөд 3 метр тутамд 3.5 метр өндөртэй шивлэр төмөр багана босгож, карказыг гагнаж холбох ба ханын дүүргэлтийг блок эсвэл нимгэн төмрөөр хийж, шалыг цементээр цутгахаар төлөвлөгдсөн.



Зураг 9-13. Загвар зураг


Хог хаягдлын цэгийн зохион байгуулалтад 1 ширхэг шатаах зүүх, 2 ширхэг хог пресслэх машин, хуванцар, лааз, ахуйн хэрэглээний хог зэргийг төрөлжүүлэн ангилах зориулалт бүхий тасалгаатай хогийн савууд төлөвлөгдөн багтсан.



Зураг 9-14. Хог хаягдлын цэгийн ахин төлөвлөлт

### 9.1.4 Хог хаягдлын тээвэрлэлт

Компанийн хог хаягдлын менежментийн зарчмын дагуу “Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг нийлүүлэх гэрээг Төвшин сайхан” -тэй “Ахуйн хуурай хог хаягдлыг нийлүүлэх” Мандах сумын засаг даргатай, “Хаягдал тос, масло нийлүүлж үстгүүлэх” гэрээг “ОБ - Ойл ХХК”, “Саус ресурс ХХК”, “Монфити - Ойл ХХК”, “Аюултай хог хаягдал шилжүүлэх” гэрээг Цэцүүх трейд ХХК компаниудтай байгуулан ажиллаж байна. Эдгээр гэрээнүүд тухайн хог хаягдлыг нийлүүлэхдээ тодорхой хэмжээ заасан байдаг бөгөөд төслийн үйл ажиллагаа эхлээд удаагүй тул тайлант онд хараахан хог хаягдлуудын нөөцийг нийлүүлэгүй байна. нөөцийг түр талбайд хадгалж байна.



Зураг 9-15. Мандах сумтай байгуулсан “Ахуйн хуурай хог хаягдлыг нийлүүлэх” гэрээ





Зураг 9-18. "ОБ - Ойл ХХК"-тай байгуулсан "Хаягдал тос, масло нийлүүлж устгуулах" гэрээ

"ОБ - Ойл ХХК"-тай байгуулсан гэрээний хүрэн төслийн үйл ажиллагааны явцад ЗҮТ-өөс гарсан 10тн хаягдал тосыг 20255 оны 10-р сарын 25 хүлээлгэн өгсөн.

**9.1.5 Хүнсний хог хаягдлын дахин боловсруулалт**

**Туршилтын зорилго**

Ахуйд гардаг хүнсний үлдэгдэл (лууван, төмс, байцаа, алим, гадил, өндөгний хальс, кофены шаар, цайны шаар гэх мэт)-ийг ашиглан байгальд ээлтэй аргаар органик бордоо гарган авах, ингэснээр хог хаягдлыг багасгах болон хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх арга замыг түрших.

**Туршилтын зорилтууд**

1. Хүнсний үлдэгдэл, хаягдал материалуудыг ялгаж, туршилтад бэлтгэх.
2. 60 литрийн багтаамжтай саванд хүнсний үлдэгдлийг зөв харьцаагаар хольж, чийг, агааржуулалтыг тохируулан хадгалах.
3. Хутгах мод, үс шүршигч, жин хэмжигчийг ашиглан туршилтын явцыг хянах (чийгшил, жин, үнэрийн өөрчлөлт зэргийг ажиглах).
4. Хаягдал материалуудын задралын явц болон компост үүсэх хугацааг тодорхойлох.
5. Гарсан компостын чанарыг үнэлж, ахуйн нөхцөлд хэрэглэх боломжийг тодорхойлох.

**Туршилтын ач холбогдол**

- **Экологийн ач холбогдол:** Ахуйн хүнсний үлдэгдлийг дахин ашиглан байгаль орчны бохирдлыг бууруулна.
- **Эдийн засгийн ач холбогдол:** Худалдан авах бордооны зардлыг хэмнэж, органик хаягдлыг үнэ цэнтэй бүтээгдэхүүн болгон хувиргана.
- **Нийгмийн ач холбогдол:** Байгаль хамгааллын дадал хэвшил төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулна.

**Ашигласан материал**

- **Үндсэн материал:** Хүнсний үлдэгдэл: Лууван, төмс, байцаа, алим, гадил, улаан лоолийн хальс, өндөгний хальс, кофены шаар, цайны шаар
- **Нэмэлт материал:** 60 литрийн багтаамжтай сав, тагтай хуванцар сав, хутгах мод, жин хэмжигч, үс шүршигч сав, хамгаалалтын бээлий, халад
- **Орчны нөхцөл:** Сүүдэртэй, салхи бага ордог, чийг багатай газар



*Зураг 9-19. Туршилтанд ашигласан хүнсний үлдэгдэл материал*

Бордоо хийх туршилтад голчлон ногоон навчит хүнсний ногоо (буцай, байцаа, салат гэх мэт)-ны үлдэгдэл ашигласан. Учир нь эдгээр ургамал хөрсний шим тэжээлд мэдрэмтгий, азотын хэрэгцээ өндөртэй, богино хугацаанд ургадаг, ургалтын өөрчлөлтөд хурдан хариу үзүүлдэг бөгөөд бордооны үр нөлөөг тодорхой, богино хугацаанд үнэлэхэд тохиромжтой байдаг.



*Зураг 9-20. Туршилтанд ашиглах материалын бэлтгэл*



Зураг 9-21: Туршилтанд орсон бараа материалыг хольж буй нь



Зураг 9-22: Туршилтын бордооны хадгалалт

Исэлдэлтийн үеийн нөхцөл болох температур, чийгшил, агааржуулалтыг зөв хослуулснаар түршилтын бордоо чанартайгаар боловсорч, бэлэн болсны дараа удаан хугацаанд хадгалах боломж бүрддэг. Тиймээс бид бэлэн болоогүй бордоог ил задгай талбайн агааржуулалттай орчинд хадгалахаар сонгосон бөгөөд энэ нь исэх процессыг идэвхжүүлж, бичил биетийн үйл ажиллагааг дэмжинэ гэж үзсэн.

### 9.1.6 Хог хаягдлын байгаль сөрөг нөлөөлөлгүйгээр устгах арга хэмжээ

“ЭЦС” ХХК нь 2025 он төслийн хог хаягдлын менежментийг сайжруулах арга хэмжээний хүрээнд Хг хаягдлын менежментийн төлөвлөгөө” боловсруулсан төлөвлөгөөний гол зорилго нь төслийн талбай дээрх үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг зөв зохистойгоор ангилах, хадгалах, тээвэрлэх, устгах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

Тус төлөвлөгөөнд төслийн хүрээнд үүсэх хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, аюулгүй устгах арга хэмжээг тодорхойлж, хаягдлыг дахин ашиглах, сэргээн боловсруулах, дахин боловсруулах боломжийг тусгасан.



МАК Цагаан суварга-ийн молибдены зэсний ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

АГУУЛГА


|   |    |
|---|----|
| АГУУЛГА   | 1  |
| 1. ОУРИЛГО  | 1  |
| 2. ҮНДЭСЛЭЛ   | 1  |
| 3. МОНГОЛ УЛСЫН АУСЫН ЗӨВӨЙН ӨНӨДӨЛ                   | 1  |
| 4. ӨНӨН УЛСЫН СУНГААР, БАГАССАЙН АНГАЙН               | 1  |
| 5. ХОГ ХАЯГДЛЫН ОДООНГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ               | 1  |
| 5.1. Хог хаягдлын төрлүүд, хэмжээ                     | 1  |
| 5.2. Хог хаягдлын төлөвлөгөөний зорилго               | 1  |
| 5.3. Хог хаягдлын түр хадгалалт                       | 1  |
| 6. ТӨСЛИЙН ХОГ ХАЯГДЛЫН СУДАЛГАА                      | 20 |
| 6.1. Төслийн нөхцөл болон төлөвлөгөөний зорилго       | 20 |
| 6.2. Дотоод менежментийн боловсрол болон хэрэгжүүлэлт | 21 |
| 6.3. Дотоод менежментийн боловсрол болон хэрэгжүүлэлт | 22 |
| 7. ХАЯГДЛЫН ХОГ ХАЯГДЛЫН АЖИЛ ТУЛГАМЖ                 | 23 |
| 7.1. Хог хаягдлын түр хадгалалт                       | 23 |
| 7.2. Хог хаягдлын менежментийн зорилго, хэрэгжүүлэлт  | 24 |
| 8. АНГАЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮНДЭСЛЭЛТ                      | 25 |





Зураг 9-24. Хог хаягдлыг тээвэрлэх, устгах дараалал

Төслийн хүрээнд дахин боловсруулах боломжтой хуванцар, гялгар уут, цахилгаан хаягдал, тос тослох материал, барилгын угсралтын тоног төхөөрөмжийн баглаа боодлоос үүссэн мод, төмрийн хаягдал зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдал үүсч байна. Эдгээр стандартын дагуу ангилан ялгалт хийсэн тохиолдолд “Төвшин Сайхан Мөнх” НҮТББ, “ОБ Индастриал” ХХК болон Мандах сумтай байгуулсан гэрээний хүрээнд хүлээлгэн өгснөөр хог хаягдлыг тодорхой хэмжээгээр бууруулах юм. Түүнчлэн эдгээр ангилалд багтахгүй бусад төрлийн хог хаягдлыг стандартын шаардлага хангасан шатаах зуухаар устгах устгахаар төлөвлөж байна. Мөн бид стандарт шаардлага хангасан шатаах зуухны судалгааг хийсэн бөгөөд бидний судалснаар “Технологи бридж” ХХК нь 2018 оноос эхлэн ОХУ-ын “ИЖТЕЛ” үйлдвэрийн тусгай зориулалтын хог хаягдал 1200 хэмд шатааж устгах зүүх инсенератор, биологийн үлдэгдэл устгах керематорийн албан ёсны дистрибьютерийн эрхийг авсан байна.



Зураг 9-25. Үйл ажилгаан ашиглахаар төлөвлөсөн утаагүй шатаах зуух

ИХСЭЭНИЙ АЖАЛТЫН  
КОМПАНИЙН СТАНДАРТ ХААГ

Төрийн үйлчилгээний байр  
Улаанбаатар, Хөвсгөл дүүрэг  
Хөвсгөл дүүрэг, Өлзийт сум,  
Хөвсгөл дүүрэг, Өлзийт сум,  
Улаанбаатар, Хөвсгөл дүүрэг,  
Хөвсгөл дүүрэг, Өлзийт сум

**ЭХЭМЭГТЭЙН ДУГААНЫ ХУДАС**

Эхний нэр: 2025.09.08  
Засварлагч нар: "Хөвсгөл Бүтэц" ХХК  
Зураач нар: 14/07  
Тусламж үзүүлэгч: Дэлгэр нар  
Хяналт үзсэн газрын нэр, өмнө: Нөмөр: 2025.09.08  
Хяналт үзсэн өдөр: 2025.09.08

| Түүхийн                  | SO <sub>2</sub><br>мг/м <sup>3</sup> | SO <sub>3</sub><br>мг/м <sup>3</sup> | CO<br>мг/м <sup>3</sup> | ТЭР<br>мг/м <sup>3</sup> |
|--------------------------|--------------------------------------|--------------------------------------|-------------------------|--------------------------|
| Төрийн үйлчилгээний байр | 224                                  | 207                                  | 4528                    | 71.3                     |
| МАК 1043.2015-0 стандарт | 450                                  | 300                                  | 5500                    | 800                      |

ТЭГЭЭНИЙ  
ИХСЭЭНИЙ АЖАЛТЫН КОМПАНИЙН  
ТӨРӨД ХААГААНЫ ДАХЬ ГЭРЧИЛГЭЭ  
АЖАЛТ

ИХСЭЭНИЙ  
ДЭГ  
КОМПАНИЙН АЖАЛТЫН  
ИХСЭЭНИЙ  
САНГААР ТӨРӨД

Х. ХОТОВСОН  
Г. ДУГААРАА  
С. ХАМБААТАЙ



Зураг 9-26. Шатаах зуухны хэмжилтийн дүн болон тохирлын гэрчилгээ

### Судалгаа хисэн зуухны техникийн үр ашиг

HPLG хог шатаах зуух нь өндөр температурт хог хаягдлыг бүрэн шатаах технологи ашигладаг. Давхар шаталтын процесс нь хог хаягдлыг бүрэн устгах үр ашгийг хангаж, тусгай бүнкерүүд болон шүүлтүүрийн систем нь яндангаас ялгарах хорт нэгдлийг бууруулдаг юм байна.

### Стандарт болон аюулгүй байдал

Үндсэн шатаах бүнкерээс гарсан дутуу шаталтыг утааг дахин шатаах бүнкерт 850C дээш хэмд шатааж цэвэршүүлэх /Gas regulation/ системтэй бөгөөд ISO 14001-2015 болон ISO 9001-2015 тохирлын гэрчилгээтэй, яндангаас ялгарах хорт утааг хэмжилт хийсэн/. Стандарт хэмжил зүйн газрын гэрчилгээтэй байна.

### 9.1.7 Хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээ

Төслийн талбай болон түүний ойр орчимд улирал тутам хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээг зохион байгуулж байна.



Зураг 9-27. Хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээ

### 9.2 АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

“Эрдэнэс Цагаан Суварга” ХХК-ийн Цагаан Суваргын зэс молибдены ордыг ашиглах төслийн барилга угсралтын үе шат явагдаж байгаа бөгөөд тайлант онд төслийн талбайд байрлах дараах 2 эх үүсвэрээс аюултай хог хаягдал үүсэж байна. Үүнд:

- Засвар үйлчилгээний төв
- Анхан тусламжийн төв

“Эрдэнэс Цагаан Суварга” ХХК нь хог хаягдлын тухай хуулийн 21.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 10-р сарын 02-ны өдрийн 61 дүгээр албан тоотор Аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж, Ү-001987 дугаар авсан. Төслийн талбайн хэмжээнд дараах аюултай хог хаягдлууд үүсэж байна.

Хүснэгт 9-2. Төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй аюултай хог хаягдлын жагсаалт

| Хог хаягдлын бүлэг  | Дэд бүлгийн код | Хог хаягдлын дэд бүлэг  | Хог хаягдлын төрлийн код | Хог хаягдлын төрөл  | Аюулын зэрэглэл |
|---|-----------------|---|--------------------------|---|-----------------|
| Гадаргуу бүрэгч материал (будаг, лак, паалан, цаеуу, чигжээс, хэвлэлийн будаг үйлдвэрлэх, бэлтгэх, тээвэрлэх, хэрэглэх үед үүсэх хаягдал) | 08 03           | Хэвлэлийн бэх үйлдвэрлэх, бэлтгэх, тээвэрлэх, хэрэглэх, арилгах үед үүсэх хаягдал | 080308*                  | Хортой бодис агуулсан хэвлэлийн хорны хаягдал (картрижийн хамт) | X               |

| Хог хаягдлын бүлэг  | Дэд бүлгийн код | Хог хаягдлын дэд бүлэг   | Хог хаягдлын төрлийн код | Хог хаягдлын төрөл   | Аюулын зэрэглэл                    |   |
|---|-----------------|--|--------------------------|--|------------------------------------|---|
| Хаягдал тос ба шингэн түлш (хүнсний тос, Д ба Л бүлгийн тос хамаарахгүй)  | 13 02           | Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал   | 130205*                  | Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны бусад тос   | A                                  |   |
|   | 13 05           | Шингэн түлшний хаягдал   | 130501*                  | Түлшний тос, дизель  | A                                  |   |
|   |                 |  | 130502*                  | Бензин   | A                                  |   |
|   |                 |  | 130503*                  | Бусад түлш (холимог түлш)  | A                                  |   |
| Сав баглаа боодлын хаягдал: Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас | 15 01           | Сав баглаа боодол (ангилаан ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно)   | 150109*                  | Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол   | A                                  |   |
|   | 15 02           | Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас  | 150201*                  | Хортой бодисоор бохирдсон шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас  | A                                  |   |
| Бусад хог хаягдал   | 16 01           | Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал (13, 14, 16 06, 16 08-аас бусад) | 160104*                  | Тосны шүүр   | A                                  |   |
|   |                 |  | 160110*                  | Тоормосны шингэн   | A                                  |   |
|   | 16 02           | Цахилгаан болон цахим тоног төхөөрөмжийн хаягдал   | 160205*                  | 16 01 01-16 01 04-д зааснаас бусад хортой бодис агуулсан хаягдал оног төхөөрөмж (16 06-д заасан батарей, аккумулятор болон мөнгөн үс агуулсан унтраагуур, катодын лампы шил гэх мэт аюултай гэж тэмдэглэсэн эд анги) | A                                  |   |
|   |                 |  |                          | 160601*  | Хартугалгатай батарей, аккумулятор | A |
|   |                 |  |                          | 160602*  | Никель-Кадмийн батарей             | A |
|   | 16 06           | Батарей, аккумулятор   | 160603*                  | Мөнгөн үс агуулсан батарей   | A                                  |   |
| Барилга, барилгын материалын хог хаягдал (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно)                                      | 17 05           | Хөрс (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно), чулуу, хүрдас  | 170501*                  | Хортой бодис агуулсан хөрс, чулуу  | X                                  |   |

### 9.2.1 Хаягдал тос, масло хадгалалт

Цагаан суваргын зэс мольбдений ордыг ашиглах төслийн дотоод хэрэгцээний агуулах, шатахуун түгээх станцын зураг төсөлд хаягдал тос хадгалах 25тн 2ширхэг ил агуулахыг төлөвлөн хийгдэж байна. Тус 2 ил агуулах саванд ажилласан масло, гидрийн ширхэг, бусад саванд автоцистернд бөөнөөр насосоор буулган



Зураг 9-28. Агуулах, шатахуун түгээх станцын батлагдсан зураг



Зураг 9-29. Хаягдал тос, масло хадгалах сав

### 9.2.2 Хаягдал тос масло устгалт, нийлүүлэлт

Төслийн хэмжээнд үүсэх хаягдал тос нийлүүлэх гэрээг "ОБ - Ойл ХХК", "Саус ресурс ХХК", "Монфити - Ойл ХХК байгуулсан бөгөөд тайлан оны 10-р сарын 25 онд төслийн талбайн хаягдал тос түр хадгалах цэгт хүримтлагдсан байсан 10тн тос маслыг аюултай хог хаягдлын дагуулах хуудсын дагуу акт үйлдэн гэрээт байгууллагад өгсөн.



Зураг 9-30. Хаягдал тосыг гэрээт байгууллагад хүлээлгэн өгч буй нь

### 9.2.3 Анхан түслэмжийн төв

Уурхайн анхан түслэмжийн төвөөс үүсэж буй эмнэлгийн аюултай хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/505-р тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”-ын дагуу төслийн талбайд түр хадгалан, Дорноговь аймгийн Мандах сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан “Эмнэлгийн түсгай хог хаягдлыг устгах гэрээ”-ний дагуу сумын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж байна. Тайлант онд 12кг эмнэлгийн халдвартай хог хаягдал 1.5кг эмнэлгийн хурц үзүүртэй иртэй хог хаягдал үүсэж түсгай зөвшөөрөлтэй байгууллагуудад шилжүүлсэн байна.



Зураг 9-31. Эрүүл мэндийн хог хаягдал түр хадгалах цэг



### 9.3 АХУЙН БОЛОН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

#### 9.3.1 Хог хаягдлын бүртгэл

Эрдэнэс Цагаан Суварга ХХК нь төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй энгийн хог хаягдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу сар бүр бүртгэж байна. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тайлант онд дараах төрлийн хог хаягдал үүссэн байна.


Хүснэгт 9-3. Тайлант онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлын жагсаалт (Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу)

| Хог хаягдлын бүлэг  | Дэд бүлгийн код | Дэд бүлэг   | Хог хаягдлын төрлийн код | Хог хаягдлын төрөл  |
|---|-----------------|---|--------------------------|---|
| Сав баглаа боодлын хаягдал: Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас | 15 01           | Сав баглаа боодол (ангиан ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно)  | 15 01 01                 | Цаасан болон кардонон сав баглаа боодол   |
|   |                 |   | 15 01 02                 | Хуванцар сав баглаа боодол  |
|   |                 |   | 15 01 03                 | Модон сав баглаа  |
|   |                 |   | 15 01 07                 | Шилэн сав   |
|   | 15 01 08        | Даавуун сав баглаа боодол   |                          |   |
|   | 15 02           | Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас   | 15 02 02                 | 15 02 01-д зааснаас бусад шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас |
| Бусад хог хаягдал   | 16 01           | Ашиглалтаас гарсан машин механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал (13, 14, 16 06, 16 08-аас бусад) | 16 01 01                 | Ашиглалтаас гарсан дугуй  |
|   |                 |   | 16 01 19                 | Тусгайлан заагдаагүй бусад эд анги  |
|   | 16 03           | Гологдол болон ашиглагдаагүй бүтээгдэхүүн (хүнсний бүтээгдэхүүн хамаарна)   | 16 03 02                 | 16 03 01-д зааснаас бусад органик биш хаягдал   |
|   | 16 06           | Батарей, аккумулятор  | 16 06 04                 | Шүлтийн батерей (16 06 03-аас бусад)  |
|   |                 |   | 16 06 05                 | Бусад төрлийн батерей, аккумулятор  |
| Барилга, барилгын материалын хог хаягдал (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно)                                      | 17 01           | Бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал   | 17 01 01                 | Бетон   |
|   | 17 02           | Мод, шил, хуванцар  | 17 02 01                 | Мод   |
|   |                 |   | 17 02 02                 | Шил   |
| 17 02 03  | Хуванцар        |   |                          |   |
| Ахуйн хог хаягдал (түүнтэй найрлага,  | 20 01           | Ангилж цуглуулсан хог хаягдал (15 01-ээс бусад)   | 20 01 01                 | Цаас, картон  |
|   |                 |   | 20 01 02                 | Шил   |

| Хог хаягдлын бүлэг   | Дэд бүлгийн код | Дэд бүлэг               | Хог хаягдлын төрлийн код | Хог хаягдлын төрөл  |
|--|-----------------|-------------------------|--------------------------|---|
| бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал) |                 |                         | 20 01 03                 | Био задралд ордог хоол, хүнсний бүтээгдэхүүний хаягдал (гал тогоо, гуанз, ресторан, кафе гэх мэт) |
|  |                 |                         | 20 01 13                 | Хүнсний өөх тос   |
|  |                 |                         | 20 01 22                 | 20 01 21-д зааснаас бусад төрлийн батарей, аккумулятор  |
|  |                 |                         | 20 01 27                 | Хуванцар  |
|  | 20 03           | Бусад ахуйн хог хаягдал | 20 03 01                 | Холимог ахуйн хог хаягдал   |
|  |                 |                         | 20 03 05                 | Бохир үс цэвэрлэгээнээс гарсан хаягдал  |
|  |                 |                         | 20 03 06                 | Овор ихтэй хог хаягдал  |

### Эрдэнэс Цагаан Суварга ХХК-ийн хог хаягдлын хэмжээ

Эрдэнэс Цагаан Суварга ХХК нь эх үүсвэр дээр үүсэж буй хог хаягдлын хэмжээг дотоод маягтын дагуу тогтмол бүртгэн, хог хаягдлын хэмжээ, төрөлд хяналт тавьж байна. 2025 оны 10-р сарын байдлаар нийт 2,638.8кг энгийн хог хаягдал үүсгээд байна.



The image shows a digital form for reporting waste management. It consists of two main columns of input fields. Each field is labeled with a category of waste and has a corresponding numerical input area. The categories include: 1. Бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал; 2. Холимог ахуйн хог хаягдал; 3. Биологийн хог хаягдал; 4. Хүнсний өөх тос; 5. Хуванцар; 6. Холимог ахуйн хог хаягдал; 7. Бохир үс цэвэрлэгээнээс гарсан хаягдал; 8. Овор ихтэй хог хаягдал.

Зураг 9-34. Хог хаягдлын бүртгэлийн маягт

Хүснэгт 9-4. Эрдэнэс Цагаан суваргын хог хаягдлын хэмжээ

| № | Хугацаа | Энгийн хог хаягдлын хэмжээ, кг |
|---|---------|--------------------------------|
| 1 | I сар   | 425                            |
| 2 | II сар  | 449.4                          |
| 3 | III сар | 443                            |
| 4 | IV сар  | 461.8                          |

| №  | Хугацаа  | Энгийн хог хаягдлын хэмжээ, кг |
|----|----------|--------------------------------|
| 5  | V сар    | 491                            |
| 6  | VI сар   | 561                            |
| 7  | VII сар  | 623                            |
| 8  | VIII сар | 635                            |
| 9  | IX сар   | 635                            |
| 10 | X сар    | 425                            |

#### Гэрээт байгууллагын хог хаягдлын хэмжээ

Эрдэнэс Цагаан Суваргын төслийн барилгын ажлын үе шат явагдаж байгаа тул баяжуулах үйлдвэрийн барилгыг барьж буй гэрээт байгууллагын 400 ажилчид төслийн талбайд байрлан ажиллаж байна. Иймд энэхүү байгууллагаас үүсэж буй хог хаягдлын хэмжээг сар бүр тогтсон маягтын дагуу бүртгэж байна.

Хүснэгт 9-5. Гэрээт байгууллагын хог хаягдлын хэмжээ (2024 он)

| № | Хугацаа | Хуванцар хог хаягдлын хэмжээ, кг | Хоолны хог хаягдлын хэмжээ, кг | Модны хаягдлын хэмжээ, кг | Төмрийн хаягдлын хэмжээ, кг | Бусад энгийн хог хаягдлын хэмжээ, кг |
|---|---------|----------------------------------|--------------------------------|---------------------------|-----------------------------|--------------------------------------|
| 1 | I       | 100                              | 300                            | 0                         | 0                           | 30                                   |
| 2 | II      | 100                              | 300                            | 0                         | 0                           | 75                                   |
| 3 | III     | 155                              | 310                            | 0                         | 150                         | 177                                  |
| 4 | IV      | 525                              | 2000                           | 200                       | 1,000                       | 2,950                                |
| 5 | V       | 1,420                            | 2,600                          | 1,000                     | 3,000                       | 4,160                                |
| 6 | VI      | 1,530                            | 3,000                          | 1,400                     | 1,800                       | 4,890                                |
| 7 | VII     | 1,645                            | 3,500                          | 2,000                     | 4,000                       | 6,115                                |
| 8 | VIII    | 1,820                            | 4,000                          | 2,500                     | 3,500                       | 2,275                                |
| 9 | IX      | 1,800                            | 4,200                          | 3,600                     | 4,500                       | 7,830                                |



График 9-1. Гэрээт байгууллагаас үүссэн хог хаягдлын хэмжээ



## БҮЛЭГ 10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

### 10.1 ЦАГ УУРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Төслийн талбай орших Дорноговь аймаг нь уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар мужид багтах бөгөөд Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их амплитуд 33.6°C, өвөлдөө хүйтэн боловч зундаа аагим халуун байдаг.


Цагаан суваргын төслийн талбайд 2012 онд Campbell брендийн CR-1000 загварын цаг уурын автомат станц суурилуулж, 2013 онд УЦУОШГ-аар баталгаажилт хийлгэсэн байдаг. Тус цаг уурын станц нь 2013 оны 04-р сарын 11-ны хүртэл хэвийн ажиллаж байгаад тэжээлийн эх үүсвэрийн тасалдалын улмаас ажиллагаагүй байсныг 2024 оны 03-р сарын 11-ны өдөр гэрээт байгууллагаар засвар үйлчилгээг хийлгэн, хэвийн үйл ажиллагаанд оруулаад байна. Цаг уурын автомат станц нь дараах иж бүрдлээс бүрдэж байна. Үүнд:

- Салхины чиглэл, хурдны мэдрүүр – RMYOUNG 05103
- Агаарын температур – 109 L
- Агаарын температур, чийгийн мэдрүүр – HMP35V
- Хур тунадасны мэдрүүр – TE525
- Нарны цацрагийн балансийн мэдрүүр – NR-LITE2
- Нарны зайн хавтан - 30W
- Аккумуляторын батарей – 12V
- Даталоггер – CR1000
- Комьпютерт холбох зориулалт бүхий кабель – RS232

Цаг уурын станцыг хувийн үйл ажиллагаанд оруулсны дараа БОМТ-д тусгасны дагуу сар бүр цаг уурын үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэж байна.

Хүснэгт 10-1. Төслийн дуу шуугианы хяналт мониторингийн цэгүүд

| № | Цэгийн нэр              | Цэгийн координат        | Хяналт мониторингийн ач холбогдол, давтамж   |
|---|-------------------------|-------------------------|--|
| 1 | CR-1000 цаг уурын станц | 49 U 286084 UTM 4861774 | Цаг уурын үзүүлэлтүүд буюу салхины чиглэл, хурд, агаарын температур, чийг, хур тунадас, нарны цацраг зэргийг хянах зорилготой 24 цагийн станц бөгөөд сар бүр датаг нэгтгэн авна. |



Зураг 10-1. Цаг уурын станцын байршил



Зураг 10-2. CP1000 цаг уурын станц

### Агаарын температур

Төслийн талбайн агаарын температурын хэмжилтийн үр дүнгээс үзэхэд агаарын дундаж температур 3-р сард 3.15°C, 4-р сард 10.97°C, 5-р сард 19.22°C, 6-р сард 23.09°C, 7-р сард 25.84°C, 8-р сард 23.8°C, 9-р сард 16.38°C байсан байна. Цаг уурын станцын сар болон өдрийн дундаж температурын харьцуулалтыг доор тусгав.

Хүснэгт 10-2. Сарын дундаж агаарын температур (°C-ээр)

| № | Үзүүлэлт          | Сар   |       |       |       |       |       |       |
|---|-------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
|   |                   | III   | IV    | V     | VI    | VII   | VIII  | IX    |
| 1 | T <sub>max</sub>  | 10.52 | 17.63 | 26.86 | 29.7  | 32.23 | 29.41 | 22    |
| 2 | T <sub>min</sub>  | -4.21 | 4.31  | 11.58 | 16.48 | 19.46 | 18.19 | 10.76 |
| 3 | T <sub>mean</sub> | 3.15  | 10.97 | 19.22 | 23.09 | 25.84 | 23.8  | 16.38 |






График 10-1. Агаарын дулаан хүйтний сарын явц






График 10-2. Агаарын дулаан хүйтний өдрийн яец

### Хур тунадасны горим

Төслийн талбайн ойр орчимд 2024 оны 10-р сарын байдлаар 117.088 мм хур тунадас унасан бөгөөд түүний ихэнх хувь нь дулааны улиралд буюу 7-9 сарын хооронд орсон байна. Сар бүр унасан нийлбэр хур тунадасны хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10-3. Сарын дундаж агаарын температур (C°-ээр)

| № | Үзүүлэлт         | Сар |       |       |       |       |       |       |
|---|------------------|-----|-------|-------|-------|-------|-------|-------|
|   |                  | III | IV    | V     | VI    | VII   | VIII  | IX    |
| 1 | Хур тунадас (мм) | 0   | 0.508 | 11.94 | 3.048 | 35.56 | 65.53 | 0.508 |




График 10-3. Сарын нийлбэр хур тунадасны явц

### Агаарын чийгшлийн горим

Агаар усны уураар ханах төлөвтөө хир зэрэг дөхөж байгааг илэрхийлэх үзүүлэлт бол харьцангуй чийгшил юм. Тэгвэл нэгж эзэлхүүнтэй агаарт агуулагдаж буй усны уурын тоо хэмжээг граммаар илэрхийлснийг үнэмлэхүй чийгшил гэнэ. Төслийн талбай орчимд нэн хуурай үүр амьсгалтай буюу жилийн дундаж харьцангуй чийгшлийн утга хэлбэлзэл ихтэй, өвлийн улиралд агаар хөрж, улмаар усны уурыг агуулах чадвар буурснаар (агаар шахагдах) ханасан төлөвтөө ойртох учраас харьцангуй чийгшил хамгийн их хэмжээндээ хүрэх ба хавар дулаарснаар (агаар тэлж) агаарын усны уурыг агуулах чадвар нэмэгдээд ирэх үед хамгийн хуурай болох учир харьцангуй чийгшлийн хамгийн бага утга 25-35% болсон байна. Харин зун хур борооны улирал эхлэхээр дахин бага зэрэг нэмэгдээд, намар эргээд буурах хэдий ч хүйтрэлт эхлэхэд агаар шахагдсанаар намрын сүүл сард өссөн байна.

Хүснэгт 10-4. Агаарын чийгшлийн үзүүлэлт (%)

| № | Үзүүлэлт                           | Сар   |       |       |       |       |       |       |
|---|------------------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
|   |                                    | III   | IV    | V     | VI    | VII   | VIII  | IX    |
| 1 | Харьцангуй чийгшил ( $RH_{max}$ )  | 55.15 | 47.17 | 41.19 | 49.96 | 66.77 | 72.60 | 79.11 |
| 2 | Харьцангуй чийгшил ( $RH_{min}$ )  | 14.56 | 14.94 | 10.16 | 14.80 | 21.60 | 25.56 | 31.02 |
| 3 | Харьцангуй чийгшил ( $RH_{mean}$ ) | 34.85 | 31.05 | 25.67 | 32.38 | 44.18 | 49.08 | 55.06 |

### Салхины хурд, чиглэл

Нарны цацраг дэвсгэр гадаргад ирээд зарим хэсэг нь буцаж ойдог бол зарим хэсэг нь түүнд шингэснээр дулааны энергид шилжинэ. Дэвсгэр гадаргын жигд бус байдлаас болоод гадарга мөн харилцан адилгүй халж, улмаар агаарын даралтын жигд бус хуваарилалт бий болно. Даралт ихтэй (хүйтэн) газраас багатай (дулаан) руугаа хэвтээ чиглэлийн дагуу шилжих агаарын урсгалыг салхи гэнэ.

Хүснэгт 10-5. Салхины дундаж хурд (м/с)

| № | Үзүүлэлт | Сар |    |   |    |     |      |    |
|---|----------|-----|----|---|----|-----|------|----|
|   |          | III | IV | V | VI | VII | VIII | IX |

|   |                          |       |       |       |       |       |       |       |
|---|--------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| 1 | Дундаж салхины хурд, м/с | 28.45 | 32.73 | 32.89 | 31.21 | 26.46 | 21.69 | 24.62 |
|---|--------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|

Төслийн бүс нутагт тайлант онд зүүн хойд (NE) болон баруун өмнөд (SE) зүгийн салхи хамгийн их давтагдалтай байсан байна.





График 10-4. Салхины чиглэлийн давтагдал (3-9-р сар)

## 10.2 ДУУ ЧИМЭЭНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Хүрээлэн буй орчинд үүсэж буй дуу шуугианы түвшин тодорхой стандарт хэмжээнээс давсан тохиолдолд хүний эрүүл мэндэд болон зэрлэг амьтдад сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг тул төслийн талбай болон түүний ойр орчимд хяналт шинжилгээг явуулан ажиллаж байна. 2024 оны БОМТ-ний дагуу 4 цэгт дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 10-6. Төслийн дуу шуугианы хяналт мониторингийн цэгүүд

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр                | Цэгийн координат        | Хяналт мониторингийн ач холбогдол, давтамж  |
|---|---------------|---------------------------|-------------------------|---|
| 1 | TS_N_1        | Ажилчдын кемп             | 49 U 286503 UTM 4862370 | Дуу чимээнээс үүсэж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, арга хэмжээ төлөвлөх, дата мэдээлэл үүсгэх зорилгоор жилд 1 удаа |
| 2 | TS_N_2        | Баяжуулах үйлдвэр-бүтлүүр | 49 U 286447 UTM 4861464 |   |
| 3 | TS_N_3        | Хогийн цэгийн баруун талд | 49 U 288229 UTM 4859585 |   |
| 4 | TS_N_4        | Хөрсний овоолго           | 49 U 285440 UTM 4860766 |   |



Зураг 10-3. Дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд



Зураг 10-4. Дуу чимээний хэмжилт

Дуу чимээний түвшинг Байгаль орчны төв лаборатороор нийт 4 цэгт хийлгэхэд стандартаас давсан үзүүлэлт илрээгүй.

Хүснэгт 10-7. Дуу чимээний хэмжилтийн үр дүн

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр                    | Дуу чимээ, ДБА |
|---|---------------|-------------------------------|----------------|
| 1 | TS_N_1        | Ажилчдын кемп                 | 52             |
| 2 | TS_N_2        | Баяжуулах үйлдвэр-<br>бүтлүүр | 56             |
| 3 | TS_N_3        | Хогийн цэгийн баруун<br>талд  | 56             |
| 4 | TS_N_4        | Хөрсний овоолго               | 42             |




График 10-5. Дуу чимээний хэмжилтийн үр дүн

### 10.3 АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Төслийн агаарын чанарын хяналт шинжилгээний ажлыг сөрөг нөлөөлөл үүсгэж болохуйц ажлын талбаруудаас хамаарч агаарын чанарын нийт 6 цэгт орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар дах тоос тоосонцор (TSP, PM<sub>10</sub>, PM<sub>2.5</sub>), хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), азотын давхар ислийн (NO<sub>2</sub>) агууламжыг жилийн турш төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 10-8. Төслийн агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр              | Цэгийн координат        | Дээж авсан цэгийн тодорхойлолт  |
|---|---------------|-------------------------|-------------------------|---|
| 1 | TS_A_1        | Хогийн цэгийн орчимд    | 49 U 288217 UTM 4859585 | Төслийн үйл ажиллагаанаас агаарын орчинд үүсэж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, тоосжилт бүүруулах арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулах, дата мэдээлэл үүсгэх |
| 2 | TS_A_2        | Хөрсний овоолго         | 49 U 285440 UTM 4860766 |   |
| 3 | TS_A_3        | Дотоод тээврийн зам     | 49 U 286150 UTM 4860301 |   |
| 4 | TS_A_4        | Бутлуур                 | 49 U 286441 UTM 4861456 |   |
| 5 | TS_A_5        | Баяжуулах үйлдвэр       | 49 U 287054 UTM 4861725 |   |
| 6 | TS_A_6        | Засвар үйлчилгээний төв | 49 U 286282 UTM 4861679 |   |



Зураг 10-5. Агаарын хяналт мониторингийн цэгүүд



Зураг 10-6. Агаарын чанарын хэмжилт хийх үеийн зураг

Агаарын чанарын үзүүлэлтүүд буюу хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламжийг Байгаль орчны төв лаборатороор 6-р болон 9-р саруудад хийж гүйцэтгүүллээ.

Хүснэгт 10-9. Агаарын чанарын хяналт шинжилгээний үр дүн

| №                   | Цэгийн дугаар | Цэгийн нэр              | 6-р сарын хяналт шинжилгээ      |                                       |                            | 9-р сарын хяналт шинжилгээ      |                                       |                            |                    |                    |
|---------------------|---------------|-------------------------|---------------------------------|---------------------------------------|----------------------------|---------------------------------|---------------------------------------|----------------------------|--------------------|--------------------|
|                     |               |                         | Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> ) | Азотын давхар исэл (NO <sub>2</sub> ) | Нийт тоосны агууламж (TSP) | Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> ) | Азотын давхар исэл (NO <sub>2</sub> ) | Нийт тоосны агууламж (TSP) | PM2.5              | PM10               |
|                     |               |                         | мкг/м <sup>3</sup>              | мкг/м <sup>3</sup>                    | мкг/м <sup>3</sup>         | мкг/м <sup>3</sup>              | мкг/м <sup>3</sup>                    | мкг/м <sup>3</sup>         | мкг/м <sup>3</sup> | мкг/м <sup>3</sup> |
| 1                   | TS_A_1        | Хогийн цэгийн орчимд    | 2.0                             | 18                                    | 630                        | 10                              | 27                                    | 87                         | -                  | -                  |
| 2                   | TS_A_2        | Хөрсний овоолго         | -                               | -                                     | -                          | 11                              | 25                                    | 120                        | -                  | -                  |
| 3                   | TS_A_3        | Дотоод тээврийн зам     | 3.0                             | 30                                    | 125                        | 15                              | 28                                    | 326                        | -                  | -                  |
| 4                   | TS_A_4        | Бүтлүүр                 | 3.0                             | 25                                    | 409                        | 13                              | 21                                    | 120                        | -                  | -                  |
| 5                   | TS_A_5        | Баяжуулах үйлдвэр       | -                               | -                                     | -                          | 11                              | 24                                    | 114                        | -                  | -                  |
| 6                   | TS_A_6        | Засвар үйлчилгээний төв | 4.0                             | 33                                    | 990                        | -                               | -                                     | 105                        | 91                 | 102                |
| <b>MNS4585:2016</b> |               |                         | <b>450</b>                      | <b>200</b>                            | <b>500</b>                 | <b>450</b>                      | <b>200</b>                            | <b>500</b>                 | <b>50</b>          | <b>100</b>         |



График 10-6. Хүхэрлэг хийн хэмжилтийн үр дүн



График 10-7. Азотын давхар исэлийн хэмжилтийн үр дүн




График 10-8. Нийт тоосны хэмжилтийн үр дүн

#### 10.4 ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ


Эрдэнэс Цагаан Суваргын төслийн талбайн хэмжээнд аараг толгод бүхий гадарга нь гуу жалгын хэрчигдэл ихтэй нам уулс болон тэдгээрийн хоорондох өргөн нарийн хуурай сайрууд, тэгшивтер хөндий болон талархаг гадарга, жижиг дов довцог, шалархуу хотгор хонхор, элсэрхэг дов зэрэг гадаргын олон янзын хэлбэрийг хамарч д.т.д 903-1050м өндөрт байрлана.

Төслийн үйл ажиллагааны үед хөрсний хими, физикийн шинж чанар, хүнд металлын агууламжид гарч болзошгүй өөрчлөлт, холбогдох стандартыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор төлөвлөгөөнд тусгасан цэгүүдэд хуваарийн дагуу хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 10-10. Төслийн хөрсний хяналтын цэгүүд

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр           | Цэгийн координат        | Дээж авсан цэгийн тодорхойлолт   |
|---|---------------|----------------------|-------------------------|--|
| 1 | TS_S_1        | Шимт хөрсний овоолго | 49 U 285559 UTM 4860998 | Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх, цаашид |

|   |        |                          |                         |  |
|---|--------|--------------------------|-------------------------|--|
| 2 | TS_S_2 | Хог хаягдлын нэгдсэн цэг | 49 U 289265 UTM 4858896 | авах арга хэмжээг төлөвлөх, дата мэдээлэл үүсгэх |
| 3 | TS_S_3 | Кемп                     | 49 U 286539 UTM 4862446 |  |
| 4 | TS_S_4 | ШТС                      | 49 U 286735 UTM 4861647 |  |
| 5 | TS_S_5 | Хөрсний овоолго          | 49 U 285440 UTM 4860776 |  |
|   |        |                          |                         |  |



Зураг 10-7. Хөрсний хяналт мониторингийн цэгүүд



Зураг 10-8. Хөрсний дээжлэлт хийх үеийн зураг

Хөрсний үржил шимийн түвшнийг тодорхойлдог голлох үзүүлэлт болох хөрсний ялзмагийн агууламж болон хөрсний хими шинж чанарын үзүүлэлтүүд буюу урвалын орчин(pH), карбонатын агууламж зэргийг тодорхойлсон бөгөөд үзүүлэлт тус бүрийн үр дүнгийн талаар доор дэлгэрэнгүй тайлбарласан болно. Үүнд:

**Хөрсний урвалын орчин(pH):** Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг, >9.0 хэт шүлтлэг гэж үздэг. Ерөнхийдөө хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиромжтой гэж үздэг. Шинжилгээний үр дүнгээс харахад хөрсний pH-ийн утга 8.5-9.5 буюу дунд зэрэг шүлтлэгээс хэт шүлтлэг урвалын орчинтой, дунджаар 8.7 байгаа нь ургамал ургахад тохиромж багатай байна.

**Хөрсний ялзмаг:** Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Ялзмагийн бодис их байх тусам хөрсний өнгө гүн хар болдог. Ялзмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг сайжруулах, чийгийн багтаамжийг нэмэгдүүлэх, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлөх, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмжих, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад бүффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэх, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болох, хөрсний агаар солилцоог сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага үнэлдэг. 6-р сар болон 9-р сарын шинжилгээний үр дүнгээс харахад хөрсний ялзмагийн агууламж 0.65-3.06% байгаа нь тайлант онд чийгийн хангамж сайтай байсантай холбоотой.

**Хөрсний хөдөлгөөнт кали, фосфор:** Хөрсний кали, фосфор нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P<sub>2</sub>O<sub>5</sub>) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорыг агууламжаар нь 1-2мг/100г бага, 2-3мг/100г дунд зэрэг хангамжтай гэж үнэлдэг. Кали нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K<sub>2</sub>O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийг агууламжаар нь 5-10 мг/100г бага, 10-15 мг/100г дунд зэрэг, 15-20 мг/100г сайн, 20-30 мг/100г маш сайн хангамжтай гэж үнэлдэг. Шинжилгээний үр дүнгээс харахад бүх хөрснүүдийн өнгөн үе давхаргад хөдөлгөөнт фосфорын хангамж 1.2-2.04 мг/кг байгаа нь сайн хангамжтай байна.

Хүснэгт 10-11. 6-р сарын хөрсний шинжилгээний хариу

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр               | pH   | Чийг | Нитратын азот (NO <sub>3</sub> ) | Сульфат (SO <sub>4</sub> ) | Фосфор | Амиакийн азот | Ялзмаг |
|---|---------------|--------------------------|------|------|----------------------------------|----------------------------|--------|---------------|--------|
|   |               |                          |      | %    |                                  |                            |        |               |        |
| 1 | TS_S_1        | Шимт хөрсний овоолго     | 9.16 | 0.34 | 10.201                           | 36.2                       | 1.02   | 767.00        | 1.55   |
| 2 | TS_S_2        | Хог хаягдлын нэгдсэн цэг | 9.54 | 0.80 | 19.392                           | 25.7                       | 1.16   | 73.83         | 2.09   |
| 3 | TS_S_3        | Кемп                     | 8.67 | 0.96 | 15.45                            | 203.1                      | 2.04   | 39.38         | 0.65   |
| 4 | TS_S_4        | ШТС                      | 9.50 | 1.12 | 5.959                            | 19.8                       | 1.89   | 66.45         | 0.90   |
| 5 | TS_S_5        | Хөрсний овоолго          | 9.58 | 1.80 | 7.956                            | 37.7                       | 1.62   | 348.77        | 3.06   |




График 10-9. Хөрс хими, физикийн үзүүлэлтүүд

## 10.5 УСАН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Цагаан Суваргын зэс молибдены ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний усан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах ажлууд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэн ажиллалаа. Үүнд:

Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр:

- Уурхайн үнд ахуйн усан хангамжийн 3 усны эх үүсвэр
- Төслийн талбайн ойр орчимд байрлах 8 малчдын гар худгийн усны статистик түвшний хэмжилт
- Уурхайн 9 хяналтын цооногийн статистик түвшний хэмжилт

Хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр


- Уурхайн 3 үнд ахуйн усны физик, химийн үндсэн үзүүлэлтүүдийн шинжилгээ
- Уурхайн 2 хаягдал усны шинжилгээ

**Үнд ахуйн усан хангамж**

Төслийн талбайн унд ахуйн усны эх үүсвэрүүдээс дээж авч, ерөнхий хими физикийн шинжилгээг хуваарийн дагуу байгаль орчны төв лаборатороор хийлгэлээ.

Хүснэгт 10-12. Төслийн унд ахуйн усны цэгүүд

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр                  | Цэгийн координат        | Дээж авсан цэгийн тодорхойлолт  |
|---|---------------|-----------------------------|-------------------------|---|
| 1 | TS_WQ_1       | Унд ахуйн худаг             | 49 U 294303 UTM 4875252 | Төслийн талбайд ажиллаж буй ажилчдын унд ахуйн усан хангамжийн цэгүүд бөгөөд усны чанарыг үнэлэх, дата мэдээлэл үүсгэхэд ач холбогдолтой. |
| 2 | TS_WQ_2       | Унд ахуйн үс (Гал тогоо)    | 49 U 286506 UTM 4861800 |   |
| 3 | TS_WQ_5       | Унд ахуйн үс (цэвэршүүлсэн) | 49 U 286465 UTM 4862428 |   |



Зураг 10-9. Төслийн унд ахуйн усны хяналт мониторингийн цэгүүд

Усны хими, физикийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд MNS 0900:2018. Ундны үс. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй байна.

Хүснэгт 10-13. Усны хими, физикийн үзүүлэлтүүд

| №                  | Цэгийн дугаар | Усны орчин (pH) | EC   | Ca    | Mg   | NaK | SO <sub>4</sub> | Cl  | HCO <sub>3</sub> | NH <sub>4</sub> | NO <sub>2</sub> | NO <sub>3</sub> | PO <sub>4</sub> | F       | Fe   |
|--------------------|---------------|-----------------|------|-------|------|-----|-----------------|-----|------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|---------|------|
| 1                  | TS_WQ_1       | 8.18            | 1814 | 13.35 | 5.35 | 355 | 198             | 229 | 287              | 0.05            | 0.003           | 3.41            | 0.004           | 3.39    | 0.01 |
| 2                  | TS_WQ_2       | 8.12            | 1884 | 4.45  | 9    | 362 | 206             | 239 | 268              | 0.08            | 0.009           | 3.43            | 0.005           | 3.38    | 0.04 |
| 3                  | TS_WQ_5       | 8.07            | 1887 | 11.86 | 3.65 | 368 | 214             | 226 | 293              | 0.06            | 0.008           | 3.45            | 0.005           | 3.40    | 0.03 |
| <b>MNS900:2018</b> |               | 6.5-8.5         | -    | 100   | 30   | -   | 500             | 350 | -                | 1.5             | 1               | 50              | 3.5             | 0.7-1.5 | 0.3  |




График 10-10. Усны шинжилгээний үр дүн

**Малчдын гар худаг** – Төслийн талбайн ойр орчимд байрлах 8 малчдын худгийн статик түвшний хэмжилтийг сар бүр хийж гүйцэтгэн дата мэдээлэл үүсгэн ажиллаж байна.

Хүснэгт 10-14. Төслийн ойр орчмын малчдын худгууд

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр          | Цэгийн координат        | Дээж авсан цэгийн тодорхойлолт   |
|---|---------------|---------------------|-------------------------|--|
| 1 | TS_HW_1       | Шавгийн үс          | 49 U 289751 UTM 4872798 | Төслийн талбайн ойр орчмын үст цэгийн мэдээллийг тогтмол бүртгэх, дата мэдээлэл үүсгэх |
| 2 | TS_HW_2       | Даравгайн гар худаг | 49 U 284109 UTM 4863665 |  |
| 3 | TS_HW_3       | Сүүжийн гар худаг   | 49 U 278718 UTM 4866406 |  |
| 4 | TS_HW_4       | Тооройн үс          | 49 U 294877 UTM 4863252 |  |

|   |         |                    |                         |
|---|---------|--------------------|-------------------------|
| 5 | TS_HW_5 | Цагаан суварга     | 49 U 292339 UTM 4857874 |
| 6 | TS_HW_6 | Шорвогийн худаг    | 49 U 285657 UTM 4862215 |
| 7 | TS_HW_7 | Хөөврийн гар худаг | 49 U 288719 UTM 4859035 |
| 8 | TS_HW_8 | Энгэр сүхайт       | 49 U 288719 UTM 4859035 |



Зураг 10-10. Малчдын гар худагууд

Хүснэгт 10-15. Малчдын худагийн статистик түвшний хэмжилтийн үр дүн


| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр          | Усны статистик түвшин, м |
|---|---------------|---------------------|--------------------------|
| 1 | TS_HW_1       | Шавгийн үс          | 1.31                     |
| 2 | TS_HW_2       | Даравгайн гар худаг | 1.10                     |
| 3 | TS_HW_3       | Сүүжийн гар худаг   | 1.1                      |
| 4 | TS_HW_4       | Тооройн үс          | 2.88                     |
| 5 | TS_HW_5       | Цагаан суварга      | 0.45                     |
| 6 | TS_HW_6       | Шорвогийн худаг     | 2.70                     |
| 7 | TS_HW_7       | Хөөврийн гар худаг  | 0.98                     |
| 8 | TS_HW_8       | Энгэр сүхайт        | 2.23                     |

**Нарангийн хоолойн хяналтын цооногууд** – Нарангийн хоолойн 9 хяналтын цооногийн статик түвшинг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хянан ажиллаж байна.

Хүснэгт 10-16. Нарангийн хоолойн хяналтын цооногууд

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр            | Цэгийн координат        | Дээж авсан цэгийн тодорхойлолт  |
|---|---------------|-----------------------|-------------------------|---|
| 1 | TS_GW_1       | Нарангийн хоолой ХЦ-3 | 49 U 292394 UTM 4874397 | Төслийн үйл ажиллагаа газрын доорх усан орчинд хэрхэн нөлөөлж буй талаар үнэлэх, цаашдын төлөвлөгөөнд ашиглах |
| 2 | TS_GW_2       | Нарангийн хоолой ЭЦ-2 | 49 U 292480 UTM 4873874 |   |

|   |         |                           |                            |
|---|---------|---------------------------|----------------------------|
| 3 | TS_GW_3 | Нарангийн хоолой ХЦ-1     | 49 U 292560 UTM<br>4873474 |
| 4 | TS_GW_4 | Нарангийн хоолой ХЦ-0920А | 49 U 293857 UTM<br>4873349 |
| 5 | TS_GW_5 | Нарангийн хоолой ЭЦ-14    | 49 U 294136 UTM<br>4876792 |
| 6 | TS_GW_6 | Нарангийн хоолой ХЦ-8     | 49 U 295515 UTM<br>4875206 |
| 7 | TS_GW_7 | Нарангийн хоолой ХЦ-7     | 49 U 296039 UTM<br>4877270 |
| 8 | TS_GW_8 | Нарангийн хоолой ХЦ-12    | 49 U 295021 UTM<br>4873175 |
| 9 | TS_GW_9 | Нарангийн хоолой ЭЦ-4     | 49 U 292424 UTM<br>4875403 |



Зураг 10-11. Нарангийн хоолойн хяналтын цооногууд


Хүснэгт 10-17. Нарангийн хоолойн хяналт цооногуудын статистик түвшний хэмжилтийн үр дүн

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр                | Усны статистик түвшин, м |
|---|---------------|---------------------------|--------------------------|
| 1 | TS_GW_1       | Нарангийн хоолой ХЦ-3     | 22.02                    |
| 2 | TS_GW_2       | Нарангийн хоолой ЭЦ-2     | 19.09                    |
| 3 | TS_GW_3       | Нарангийн хоолой ХЦ-1     | 3.42                     |
| 4 | TS_GW_4       | Нарангийн хоолой ХЦ-0920А | 11                       |
| 5 | TS_GW_5       | Нарангийн хоолой ЭЦ-14    | Лацтай                   |
| 6 | TS_GW_6       | Нарангийн хоолой ХЦ-8     | 18.81                    |
| 7 | TS_GW_7       | Нарангийн хоолой ХЦ-7     | 23.48                    |
